



МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ, 2025

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг. Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг баталсан.

Тус баримт бичигт Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Амар тайван аюулгүй нийгэм, Бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлж, 243 хүрэх үр дүнг тодорхойлсон.

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нийт 95 шалгуур үзүүлэлт, түүний суурь түвшинг 2018, 2019, 2020 оноор, хүрэх түвшинг 2025 оноор тус тус тодорхойлж баталсан.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг үнэлэхдээ Засгийн газрын “Журам батлах тухай” 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан журмыг баримтлан Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хэрэгжүүлэгч яам, агентлаг, холбогдох бусад байгууллагаас ирүүлсэн тайлан, шалгуур үзүүлэлтийн хүрсэн үр дүнгийн талаарх мэдээлэл, Үндэсний статистикийн хорооны статистик үзүүлэлт болон бусад мэдээллийг үндэслэл болгов.

Хоёр. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төлөвлөлт, бодлогын уялдаа

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд зааснаар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичиг бөгөөд “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 25.2 хувийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.


Хүснэгт 1. Бодлогын баримт бичиг хоорондын уялдаа:

Д/д	Бодлогын чиглэл	Алсын хараа 2050 (2021-2030)		Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл			Үндсэн чиглэлд тусгасан хувь
		Зорилт	Үйл ажиллагаа	Зорилго	Зорилт	Хүрэх үр дүн	
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	5	64	1	5	17	26.6
2	Хүний хөгжил	7	161	1	7	49	30.4
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	6	89	1	6	27	30.3
4	Эдийн засаг	6	165	1	6	35	21.2
5	Засаглал	6	99	1	6	25	25.3
6	Ногоон хөгжил	4	64	1	4	18	28.1
7	Амар тайван, аюулгүй нийгэм	5	116	1	5	23	19.8
8	Бүс, орон нутгийн хөгжил	3	57	1	3	28	49.1
9	Улаанбаатар ба дагуул хот	5	150	1	5	21	14.0
ДҮН		47	965	9	47	243	25.2

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13, 6.10.1-т заасны дагуу Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, төсөв, санхүүгийн эх үүсвэрийг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ёстой.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг 2021-2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хэрхэн тусгаж төлөвлөсөн байдлыг авч үзэхэд, дээрх бодлогын баримт бичигт тусгасан 2 зорилтын хүрээнд хамаарах 9 хүрэх үр дүнд чиглэсэн арга хэмжээг 2022-2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлээгүй байна.

Зураг-1. Үндсэн чиглэлд тусгасан үр дүнг жилийн төлөвлөгөөнд тусгасан байдал:



Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үр дүнг тодорхойлох батлагдсан нийт 95 шалгуур үзүүлэлтээс 82 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг жилд 1 удаа, 5 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг 5 жилд нэг удаа, 4 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг 2 жилд 1 удаа, 2 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг улирал бүр байхаар тус тус баталсан бөгөөд 2 шалгуур үзүүлэлтийн мэдээлэл цуглуулах давтамжийг тодорхойлоогүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний 95 шалгуур үзүүлэлтийн 30.5 хувь буюу 29 нь үндэсний үр дүнг тодорхойлох ерөнхий үзүүлэлтүүд байгаа бол 69.5 хувь буюу 66 нь салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчийн, хөтөлбөрийн хүрээний үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой үзүүлэлтүүд байна.

Гурав. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, ... биелэлтийн явцыг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор Улсын Их Хурал хэлэлцэнэ.” гэж заасны дагуу жил бүр Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж байсан ба жил тус бүрийн хэрэгжилтийн үнэлгээг авч үзвэл, дараах байдалтай байна.

Хүснэгт-2. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ:

№	Бодлогын чиглэл	Хэрэгжилтийн үнэлгээ			
		2022	2023	2024	ҮАГ (2024) үнэлгээ
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	69.1	80.0	45.0	60.6
2	Хүний хөгжил	68.2	79.8	68.4	75.1
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	77.9	90.0	67.8	71.1

4	Эдийн засаг	71.5	84.0	77.4	70.9
5	Засаглал	58.6	60.8	61.2	68.8
6	Ногоон хөгжил	74.3	70.6	77.2	55.6
7	Амар тайван, аюулгүй нийгэм	83.9	91.7	83.5	80.0
8	Бүс, орон нутгийн хөгжил	83.5	82.1	50.3	51.1
9	Улаанбаатар ба дагуул хот	80.6	80.5	50.5	65.2
Дундаж		74.2	80.4	67.0	67.7

Дээрх бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталж, бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа уг журамд заасны дагуу зорилт, арга хэмжээ бүрийн хэрэгжилтийн арифметик дунджаар тооцдог байсан болно.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэгт заасны дагуу Үндэсний аудитын газраас Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2021-2024 оны гүйцэтгэлийн тайланд аудит хийж, Улсын Их Хуралд танилцуулсан. Тус байгууллагаас Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 67.7 хувьтай хэрэгжсэн гэж дүгнэсэн байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үр дүнг батлагдсан 95 шалгуур үзүүлэлтээр үнэлж, нэмэлт 96 үзүүлэлт, түүнтэй холбоотой мэдээллийг тухайн зорилго, зорилтын үр дүнг илэрхийлэхэд ашиглав.

3.1. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ


Үндэсний нэгдмэл үнэт зүйл бодлогын хүрээнд “Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлж, энэхүү зорилгыг хангах хүрээнд Монгол хүний нэгдмэл үнэт зүйлийг бий болгох, үндэсний бахархал, эв нэгдлийг хангах, нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, үндэсний Монгол хэл, бичгээ хэрэглэж хэвшүүлэх, үнэт зүйлийн болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн судалгааг хөгжүүлэх, олон улс дахь Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлааг бэхжүүлж, монгол соёлын хүрээг тэлэх зэрэг үндсэн 5 зорилтыг тодорхойлж, 16 хүрэх үр дүнг төлөвлөсөн.

“Үндэсний нэгдмэл үнэт зүйл” зорилго, зорилтын хэрэгжилт, үр дүнг хэмжих тодорхой шалгуур үзүүлэлт, суурь түвшин байхгүй тул тэдгээрийг тодорхойлох зорилгоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас 2021 онд “Үндэсний соёл-нэгдмэл үнэт зүйлийн индексийн арга зүйг тодорхойлж, олон нийтийн санаа бодлын судалгаа”-г гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, хөгжлийн бодлогын үндэсний нэгдмэл үнэт зүйл зорилго, түүнд хамаарах 5 зорилтын хүрэх үр дүнгийн суурь түвшинг тогтоож, үндэсний нэгдмэл байдлыг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйлсийг үнэлгээний аргаар тодорхойлсон байна.

“Үндэсний нэгдмэл үнэт зүйл” зорилгын үр дүнг “Үндэсний нэгдмэл байдлын түвшин” шалгуураар тодорхойлж, 2021 оны үнэлгээгээр уг үзүүлэлт 49.0 хувь байна.

Дээрх зорилгод хамаарах 5 зорилтын үр дүнг үндэсний бахархал, эв нэгдлийн түвшин, нүүдлийн ахуй, соёлоо уламжлалт хэлбэрээр хадгалж үлдсэн байдал, Монгол хэл, бичгийн чадамж, нийгмийн соён гэгээрлийн түвшин, Монгол Улс, монгол соёлын дэлхийд танигдсан байдал гэсэн шалгуураар үнэлж, суурь түвшинг тогтоосон. Үндэсний бахархал, эв нэгдлийн түвшинг үндэсний бахархлын түвшин, үндэсний эв нэгдлийн түвшин гэсэн үзүүлэлтээр, Монгол хэл, бичгийн чадамжийг монгол хэлний чадамжийн түвшин, монгол бичгийн чадамжийн түвшин гэж ангилж үнэлсэн байна.

Зураг-2. “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” зорилгын 5 зорилтын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн суурь түвшин:



“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” зорилгын хэрэгжилтийг хэмжих “Шинэ бүтээл, патентын мэдүүлэг, дотоодын мэдүүлэг”, “Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь”, “1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо” шалгуур үзүүлэлтийг баталсан бол Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд эдгээр шалгуур үзүүлэлтээс гадна “Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж”, “Төрийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо”, “Урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь” гэсэн шалгуур үзүүлэлтийг нэмж, нийт 6 шалгуур үзүүлэлтээр зорилгын үр дүнг хэмжихээр баталсан. Эдгээр шалгуур үзүүлэлтийн хүрээнд төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэхийг тооцож үзвэл:

Хүснэгт-3. Батлагдсан шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин				
					2021	2022	2023	2024	2025.11
1	Шинэ бүтээл, патентын мэдүүлэг, дотоодын мэдүүлэг	тоо	82	150	112	111	81	94	63
2	Номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь	хувь	0.3	5	0.31	0.3	1.09	1.24	2
3	1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо	тоо	32	37	38.6	38	37	36.4	37.2
4	Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж	хувь	47.1	56.0	42.3	23.1	31.2	57.4	31.3
5	Төрийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо	хувь	21.6	23.9	10.4	7.9	25.3	33.2	73.5
6	Урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь	хувь	8.1	17.1	8.2	5.5	23.7	23.6	25.5

Шинэ бүтээл, патентын мэдүүлэг, дотоодын мэдүүлэг, номын сангийн нийт сан хөмрөгт цахим сан хөмрөгийн эзлэх хувь, соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж гэсэн шалгуур үзүүлэлт төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй бол 1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудлын тоо, төрийн өмчийн музейн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдэд хүүхдийн эзлэх хувь гэсэн шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн байна.

Дээрх 6 шалгуур үзүүлэлт нь “Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ.” зорилго, зорилтын хэрэгжилт, үр дүнг илэрхийлэх боломжгүй байгаа тул дараагийн дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа бодлогын зорилго, зорилтын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг дээр дурдсан “Үндэсний нэгдмэл байдлын түвшин болон бусад дэд шалгуураар тогтмол хугацаанд хэмжиж, үр дүнг тооцож байхаар тусгах шаардлагатай байна.

3.2.ХҮНИЙ ХӨГЖИЛ

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд “Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.” гэсэн зорилгыг дэвшүүлж, боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, шинжлэх ухаан, инновац, хүнд ээлтэй амьдрах орчин, хөдөлмөрийн зах зээл, монгол хүний удмын сан гэсэн чиглэлээр 7 зорилт, 49 хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилгын хэрэгжилт, үр дүнг хүний хөгжлийн урт хугацааны хөгжлийн төлөв байдлыг илэрхийлэх “Хүний хөгжлийн индекс” шалгуур үзүүлэлтээр авч үзвэл, батлагдсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Хүний хөгжлийн индекс” 2019 онд 0.74 байсныг 2025 онд 0.77-д хүргэх зорилт тавьсан бөгөөд 2021 онд өмнөх оноос 0.02 нэгжээр буурч, харин 2022-2024 онд 0.004-0.003 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

Хүний хөгжлийн индексийг дундаж наслалт, боловсролын түвшин, нэг хүнд ногдох орлогын үзүүлэлт тус бүрээр авч үзвэл:

Зураг 3. Хүний хөгжлийн бүрэлдэхүүн индекс



3.2.1. Боловсрол


Боловсролын чиглэлээр “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхдийг сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах, сургалтын чанарын үндэсний үнэлгээг жил бүр хийх, Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн өмчит их сургуулийн засаглалыг төрөөс хараат бус болгох, Засгийн газрын тэтгэлгээр суралцагчдыг хөдөлмөрийн зах зээлийн захиалгатай уялдуулан мэргэжлээр нь томилон ажиллуулах, багшийн нийгмийн баталгааг хангах, боловсролын хүртээмжийг хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан нэмэгдүүлэн, тэгш байдлыг хангах, ерөнхий боловсролын сургуульд “Үдийн хоол” үйлчилгээг нэвтрүүлэх, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлэх, боловсролын үйлчилгээг цахимжуулах, олон улсад өрсөлдөж чадахуйц

үндэсний боловсролын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэх зэрэг үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын үр дүнг боловсролын хамран сургалт, бүлэг дүүргэлт, нэг багшид ногдох хүүхдийн тоо, ажил эрхэлж байгаа төгсөгчдийн нийт төгсөгчдөд эзлэх хувь зэрэг батлагдсан шалгуур үзүүлэлтээр тодорхойлохын зэрэгцээ цаашид сурлагын амжилтын олон улсын үнэлгээг боловсролын салбарын үр дүнг илэрхийлэх нэг шалгуур үзүүлэлт болгон авч үзэх шаардлагатай.

- Хүний хөгжлийн индексийн бүрэлдэхүүнд багтдаг боловсролын түвшний индексийн сүүлийн 5 жилийн үзүүлэлтийг авч үзэхэд, 2020, 2021 онд өмнөх оноос 0.035 нэгжээр өссөн хэдий ч 2022-2024 онд 0.007 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх таван жилийн үр дүнгээс өссөн дүнтэй байгаа нь боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн гэж дүгнэх боломжтой байна.

Зураг 4. Боловсролын түвшний индекс



- Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин ковидын цар тахлын үр нөлөөгөөр 2020, 2021 онд буурсан хэдий ч танхимын сургалт сэргэснээр энэ үзүүлэлт тогтвортой өссөн байна. 2024-2025 оны хичээлийн жилд 1407 цэцэрлэгийн 9226 бүлэгт 264,818 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, хамран сургалт улсын хэмжээнд 90.6 хувь болж, төлөвлөсөн үр дүнгээс 1.2 хувийн ахицтай хэрэгжсэн. 2025-2026 оны хичээлийн жилд 2-5 насны хамран сургалтыг 92 хувьд буюу 1.4 хувиар нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас санаачлан цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн бөгөөд улсын хэмжээнд хэрэгжүүлэн хамран сургалт 90.6 хувьд хүрсэн. Үүний үр дүнд 2024-2025 оны хичээлийн жилд 3-5 насны хүүхдийн 92.9 хувь нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж өмнөх жилээс 0.1 нэгжээр өссөн байна.

- Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин суурь түвшнээс 0.1-2.1 нэгж хувиар ахиж, төлөвлөсөн үр дүндээ хүрсэн байгаа бол 5 настай хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт суурь түвшнээс 1.2-4.7 нэгж хувиар ахисан хэдий ч 2025 онд хүрэхээр төлөвлөсөн зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Хүснэгт 4. Боловсролын хамран сургалтын үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин				
					2021	2022	2023	2024	2025
1	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	81.5	89.4	76.9	86.5	89.7	90.6	90.6
2	5 настай хүүхдийн сургуулийн өмнөх	хувь	90.1	100.0	91.3	93.4	94.8	94.1	94.1

	боловсролд хамрагдалт								
3	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	хувь	94.9	95.9	95	95.5	95.4	97.0	97.0

Сургуулийн насанд хамаарах 6-18 насны хүүхдийн сургуульд бүрэн хамрагдахгүй байгаа нь олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа бөгөөд эдгээрээс хавсарсан хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээл, амьжиргааны түвшин, малчин өрхийн цаг агаарын бэрхшээл, ган зудаас үүдэлтэй амьжиргааны доройтол, бага ангидаа сургууль завсардсан шалтгаан ихэнх хувийг эзэлж байна. Тухайлбал хөгжлийн бэрхшээлийн улмаас боловсролын гадна байгаа сургуулийн насны хүүхэд 1263, ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 6273 байна. Сүм хийдэд шавилан суудаг сургуулийн насны хүүхэд 515 байгаагаас ерөнхий боловсролын үйлчилгээнд 317 хүүхэд хамрагдаж байна. Асрамж, халамжийн төвд амьдардаг сургуулийн насны 974 хүүхдээс 966 нь ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна. Засгийн газрын 2024 онд баталсан Бурхны шашны сургалтын байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай 48 дугаар тогтоолын дагуу нийслэлийн ерөнхий боловсролын 112 дугаар сургуулийг түшиглэн сүм хийдэд шавилан сууж буй сургуулийн насны хүүхэд болон гадаад улсад бурхны шашны чиглэлээр суралцаж буй иргэдэд ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх, зайн цахим сургалтад хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Бага, дунд боловсролын хүртээмжтэй холбоотой тулгамдсан асуудлын нэг нь 2030 он хүртэлх бага, дунд боловсрол эзэмших хүүхдийн тооны өсөлт юм. Хүн ам зүйн энэхүү өөрчлөлт нь бүлэг дүүргэлт, ээлжийн коэффициентийг улам нэмэгдүүлэхээр байгаа ба цаашлаад сургалтын чанарт ч нөлөөлөх талтай. Иймд Боловсролын яамнаас Боловсролын чанарын ялгааг арилгах чиглэлээр суралцагчийн тооноос шалтгаалан ээлжийн коэффициент өндөр байгаа ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх замаар ачааллыг бууруулах, нэг багшид ногдох суралцагчийн тоог багасгах, суралцагч хичээлээс гадуур сургуулийн орчинд хөгжих, дугуйлан, бусад хөтөлбөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

• Монгол Улсын Их Хурлаас 2023 онд баталсан боловсролын багц хуульд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах эрхийг баталгаажуулж, боловсролын зарчим тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байхыг тодорхойлж, бүх дагалдах хуульд уг зарчмыг баримтлахаар эрх зүйн зохицуулалтыг тусгасан. Энэ хүрээнд цэцэрлэг сургуульд тэгш хамран суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээг үнэлж, суралцахуйн тохируулга хийх, тохирох хэрэглэгдэхүүн, хүртээмжтэй сурах бичиг /брайль, томруулсан, цахим, сонсдог г.м/-ээр хангах, багшийн туслах ажиллуулах, боловсролд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, иргэний нийгмийн байгууллагаар зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээнд үндэслэн боловсрол эзэмшихэд нь дэмжих үйлчилгээг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчдыг хүүхэд хөгжлийн үйл ажиллагааны мэдээллээр хангах, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зэрэг тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж ажилласны үр дүнд ЕБС, СӨБ хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эзлэх хувь жил тутам нэмэгдэж байна.


Хүснэгт 5. ЕБС, СӨБ, МБСБ, их дээд сургуульд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй суралцагч

Үзүүлэлт	Хичээлийн жил			
	2021-2022	2022-2023	2023-2024	2024-2025

СӨБ, ЕБС суралцагч	Бүгд	6671	7171	8260	8423
	СӨБ	1065	1498	1977	2150
	ЕБС	5606	5673	6283	6273
МБСБ, Их дээд сургуульд суралцагч	Бүгд	1182	1057	1126	1089
	МБСБ	777	643	638	653
	Их, дээд	405	414	488	436

- Боловсролын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийн нэг бол сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлт, нэг багшид ногдох хүүхдийн тоо бөгөөд эдгээр асуудлын хүрээнд үндсэн чиглэлд тусгасан зорилтын хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна. Цэцэрлэг, сургуулийн бүлэг дүүргэлтийг 2025 онд 25-30 хүртэл бууруулах зорилт тавьсан ч 2025 онд цэцэрлэгийн бүлэг дүүргэлт 28.7 байгаа бол сургуулийн бүлэг дүүргэлт 30.4 байна.

Зураг 5.Цэцэрлэг, сургуулийн бүлэг дүүргэлт




Улсын хэмжээнд цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийн дундаж 28.8, сургуулийн бүлэг дүүргэлт 30.4 байгаа бөгөөд нийт 1407 цэцэрлэгийн 38 хувь буюу 535 цэцэрлэг 25-аас доош бүлэг дүүргэлттэй байгаа бол ерөнхий боловсролын сургуулийн хувьд стандарт хэмжээнд буюу 35 ба түүнээс доош бүлэг дүүргэлттэй сургуулийн эзлэх хувь 71.7 хувь байна. Бүлэг дүүргэлтийн ачаалал хэт өндөр буюу 44-өөс дээш хүүхэдтэй хичээллэж буй төрийн өмчийн 7 сургууль байгаа нь нийслэлийн Баянзүрх дүүрэгт 3, Хан-Уул дүүрэгт 2, Чингэлтэй дүүрэгт 1, Сүхбаатар дүүрэгт 1 сургууль тус тус байна. Өнгөрсөн 2024-2025 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр, нийслэлийн 9 дүүргийн 70 хороо төрийн болон орон нутгийн өмчийн сургуульгүй, 58 хороо огт сургуульгүй байна.

Нийслэл болон хүн ам олонтой аймгийн төвийн сургуулиудад бүлэг дүүргэлт стандарт хэмжээнээс хэтэрсэн асуудлууд бодитоор байгаа тул цаашид хүүхдийг аль болох гэрийн ойр сургуульдаа хамран сургах тойргийн аргачлалын дагуу хамруулах, сургалтын чанарын байршлаас хамаарсан ялгааг арилгахад чиглэсэн бодлого, хот, суурин газрын сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх "Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги", "Гэрт ойр сургууль/цэцэрлэг-хамгийн сайн сургууль/цэцэрлэг" арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

- Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоог 2025 онд суурь түвшнээс 26.7 хувиар, сургуулийн бага ангийн багшид ногдох хүүхдийн тоог суурь түвшнээс 19.6 хувиар бууруулахаар төлөвлөсөн бөгөөд 2025 оны дүнгээр цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо 29, сургуулийн бага ангийн багшид ногдох хүүхдийн тоо 30.5 байгаа нь зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Зураг 6. Бага ангийн нэг багш, цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо



- Боловсролын чанар, үр дүнг суралцагчдын сурлагын амжилтын шалгуур үзүүлэлтээр хэмжих боломжтой бөгөөд PISA үнэлгээ нь сурагчид суурь боловсрол эзэмших хүртэлх хугацаанд /15 нас хүртэл/ боловсролын байгууллагаар дамжуулан олж авсан мэдлэгээ амьдралд хэрхэн ашиглаж байгааг үнэлдэг.

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын 3 жил тутамд зохион байгуулдаг олон улсын сурлагын амжилтын PISA үнэлгээнд Монгол Улс 2022 онд анх удаа хамрагдсан бөгөөд үнэлгээнд 196 сургуулийн 7300 сурагч сонгогдон оролцож, тус үнэлгээнд оролцсон 81 орноос математик чиглэлээр 425 оноо авч 47 дугаар байр, унших чадвар чиглэлээр 378 оноогоор 67 дугаар байр, байгалийн ухаан чиглэлээр 412 оноо авч 53 дугаар байранд тус тус орсон байна. Үнэлгээг математик, унших чадвар, байгалийн ухаан гэсэн гурван төрлөөр тогтмол зохион байгуулдаг ба 2022 оны тухайд бүтээлч сэтгэлгээний сорилууд нэмэлтээр багтсан байна.

Боловсролын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д “Боловсролын чанарыг гурван жил тутам олон улсын эрх бүхий байгууллагаар үнэлүүлнэ” гэж заасны дагуу Монгол Улс 2025 оны PISA үнэлгээнд 2 дахь удаагаа хамрагдсан ба үнэлгээний дүн 2026 онд гарна.


3.2.2. Эрүүл мэнд

Дээрх зорилгын хүрээнд “Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ.” зорилтыг дэвшүүлж, халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх, иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулах, иргэд оршин байгаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлэх, яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг үндэсний түвшинд сайжруулах, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулах, эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэх, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны үр дүнг 13 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр баталсан. Эдгээр шалгуур үзүүлэлтээр төлөвлөсөн зорилтот түвшиндээ хүрсэн эсэхийг авч үзэхэд, 4 шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн бол 8 шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй, 1 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний талаар судалгаа хийгдээгүй тул тодорхой мэдээлэл гарах боломжгүй байна.

Эрүүл мэндийн салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлэх чухал үзүүлэлтийн нэг бол хүн амын дундаж наслалт бөгөөд үндсэн чиглэлд дундаж наслалтыг 74-т хүргэхээр төлөвлөсөн. 2021 онд суурь түвшнээс 1.15 хувиар өссөн бол 2021-2024 онд 0.308-0.379 хувиар өссөн ч төлөвлөсөн зорилтот түвшиндээ хүрээгүй байна.


Зураг 7. Хүн амын дундаж наслалт



Эрүүл мэндийн салбарын үзүүлэлтийн хүрээнд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшинг суурь түвшнээс 3.0 промилээр бууруулах, 100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцааг 4.8 промилээр бууруулах, нэг эмэгтэйд ногдох төрөлтийн нийлбэр коэффициентийг 0.4-ээр нэмэгдүүлэх зорилтыг тавьсан. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 2025 оны эхний хагас жилийн байдлаар 14 байгаа нь зорилтот түвшинд хүрээгүй байгаа ба нялхсын эндэгдлийн шалтгааныг авч үзвэл, перинаталь үеийн эмгэг 58.0 хувь, төрөлхийн хөгжлийн гажиг 17.9 хувь, амьсгалын замын тогтолцооны эмгэг 6.9 хувийг тус тус зонхилон эзэлж байна.

100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа 2025 оны эхний хагас жилийн байдлаар 33.3 байгаа нь мөн зорилтот түвшинд хүрээгүй байна.

Зураг 8. Эх, нялхсын эндэгдлийн түвшин, харьцаа



Монгол Улсад сүүлийн 10 жилийн хугацаа буюу 2015-2024 онд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаанд зүрх судасны тогтолцооны өвчин, хавдар, гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад эмгэг, хоол боловсруулах тогтолцооны өвчин болон амьсгалын тогтолцооны өвчин багтаж байна. 2024 оны жилийн эцсийн эрүүл мэндийн статистик мэдээллээр зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 100,000 хүн амд 16.9, хавдар 13.2, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 9.8, хоол боловсруулах тогтолцооны эмгэг 3.6, амьсгалын тогтолцооны эмгэгийн шалтгаант нас баралт 2.9 байгаа ба эдгээр нь тэргүүлэх 5 шалтгаан болж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт 0.2 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 9. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10 000 хүн амд, 2015-2024



Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны нэгт зүрх судасны тогтолцооны өвчин орж, артерийн даралт ихсэх өвчин хамгийн түгээмэл бүртгэгдэж, үүнээс анхдагч даралт ихсэх өвчин 10.9 хувь, даралт ихсэх бусад өвчин 35.0 хувийг эзэлж байгаа бөгөөд нийтдээ өвчлөлийн 45.9 хувийг эзэлж байна.

Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувийг 12.4 хувиар нэмэгдүүлж, 87.0 хувьд хүргэх зорилт биелээгүй байна.


Зураг 10. Эрт илрүүлгийн хамралтын хувь



Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь 2025 оны эхний хагас жилийн байдлаар 35.7 хувь, чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь 45 хувь, хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь 20.6 байна. Иргэдийн эрт илрүүлэгт хамрагдах идэвх сул, мөн эрүүл мэндийн байгууллагын мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотойгоор иргэдийг эрт илрүүлгийн үзлэгт хамруулах үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжихгүй байна.

Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувийг 0.1 нэгж хувиар нэмэгдүүлж, 99.0 хувьд хүргэх зорилт тавьсан ч 2021-2025 онд зорилтот түвшиндээ хүрээгүй, суурь түвшнээс буурсан үзүүлэлттэй байна.


Зураг 11. Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь



УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы хуралдаанаар Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог эрүүл мэндийн салбарт нэвтрүүлсэн. Уг тогтолцооны өөрчлөлтийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар тусламж үйлчилгээг худалдан авах Нэг худалдан авагчийн үүргийг гүйцэтгэж байгаа ба бүх төрлийн тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна.

Дээрх зорилтын хүрээнд баталсан шалгуур үзүүлэлтийн нэг бол эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувийг суурь түвшнээс 3.0 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 90.0 хувь, 2021-2025 оны дунджаар 93.4 хувь нь байгаа зорилтот түвшинд хүрсэн гэж үзэж болох боловч энэ үзүүлэлтийн өсөлтийг тогтвортой хангаж чадаагүй байна. Энэ нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн хүрч очих үйлчилгээ дутмаг, тогтмол, тасралтгүй мэдээлэл, сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа, зохион байгуулалтын арга хэмжээ хангалтгүй байгаагаар холбоотой байна.

Зураг 12. Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь




3.2.3. Гэр бүл

“Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ.” зорилтыг дэвшүүлж, хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх, хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшилийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, залуу гэр бүлийг дэмжсэн орчин нөхцөлийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин


нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангах, хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байлгах чиглэлээр эрх зүйн орчныг чангатгаж, хэрэгжилтэд хатуу хяналт тавих тогтолцоог бий болгох зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Гэр бүл, хүний хөгжлийг дэмжих үйл ажиллагааны үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт батлагдаагүй тул Монгол Улсын хүн амын өсөлт, 1000 хүнд ногдох гэрлэлт, цуцлалтын харьцаа, гэр бүлийн зөвлөгөө өгөх төвийн тоо, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд амьдарч байгаа хүүхдийн тоо, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байраар үйлчлүүлсэн хүний тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх хувь зэрэг үзүүлэлтээр үр дүнг тодорхойлов.


Зураг 13. Хүн амын өсөлтийн хувь



Зураг 14. Гэрлэлт, цуцлалтын харьцаа




Зураг 15. Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд амьдарч байгаа хүүхдийн тоо



Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд амьдарч байгаа хүүхдийн тоо 2020 онд 432.2 мянга байсан бол 2025 онд 509.1 мянга болж өссөн байна.

Зураг 16. гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой үзүүлэлт




3.2.4. Шинжлэх ухаан

“Шинжлэх ухаан, технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлнэ.” зорилтын хүрээнд шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын

судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг нэмэгдүүлэх, хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулж, эрдэм, шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг татварын бодлого, эдийн засгийн хөшүүргээр дэмжсэн эрх зүйн шинэчлэлт хийх, шинжлэх ухаан, технологи, инновацын дэд бүтцийг бий болгож, төрөлжсөн нээлттэй лабораторийг байгуулж, шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгыг ашиглалтад оруулах, эрдэм шинжилгээний ажилтны мэдлэг чадвар, бүтээлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг олон улсын үнэлгээний жишигт нийцүүлж, үр дүнд тохирсон цалин, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэх, хэмжил зүйн лабораторийг олон улсын жишигт хүргэх, шинжлэх ухааны байгууллагуудын бүтээл, судалгааны үр дүнг их, дээд сургуулийн сургалтад ашигладаг механизмыг бүрдүүлж, сургалт, судалгаа, инновацын төвүүдийг их, дээд сургуулиудад байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний батлагдсан шалгуур үзүүлэлтэд “Шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь”-ийг 2019 онд 0.18 хувь байсныг 2025 онд 2.5 хувьд хүргэх зорилт тавьсан бөгөөд 2022 онд өмнөх оноос 0.02 нэгжээр өсч, 2022-2024 онд өмнөхөөс оноос буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 17. Шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь



3.2.5. Хүнд ээлтэй амьдрах орчин

“Эрүүл баталгаат орчныг бий болгоно.” зорилтын хүрээнд хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадвартай болгож, хүнсний аюулгүй байдал хангах, хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх, орон сууц, ногоон байгууламжийн стандартыг олон улсын түвшинд хүргэх, агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлэх, хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, эрүүл мэндийн болон орчны тандалт, нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бий болгох зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын үр дүнг хэмжих шалгуур батлагдаагүй тул дараах шалгуураар үр дүнг тодорхойлов.

- Хүнсний баталгаат байдлын дунд болон хүнд хэлбэрийн алдагдалтай хүн амын эзлэх хувь

Үндэсний статистикийн хорооноос хүнсний аюулгүй байдлын дунд болон хүнд түвшинд хүрсэн хүн амын эзлэх хувийг хэмжих үзүүлэлтийг 2020 оноос эхлэн тооцож, хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг 2023 онд баталсан байна. 2020-2022 оны үзүүлэлтээс харахад, хүнд хэлбэрийн хүнсний баталгаат байдлын алдагдалтай хүн амын эзлэх хувь өсөж, дунд болон хүнд хэлбэрийн хүнсний баталгаат байдлын алдагдалтай хүн амын эзлэх хувь буурсан байна.

Зураг 18. Хүнсний баталгаат байдлын алдагдалтай хүн амын эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2024

Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүү, техникийн дэмжлэгээр “Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгааг 2023-2024 онд Монгол Улсын эдийн засгийн 4 бүс, 21 аймгийн 112 сум, нийслэлийн 8 дүүргийн анхан шатны 200 түүврийн нэгжид зохион байгуулсан байна. Уг судалгаанд хамрагдсан 5 хүртэлх насны хүүхэдтэй өрхийн 21.6 хувь хүнсний баталгаат байдал дунд зэрэг болон ноцтой алдагдсан, 18.9 хувь дунд зэрэг алдагдсан, 2.7 хувь хүнсний баталгаат байдал ноцтой алдагдсан гэж дүгнэсэн байна.

Хүснэгт 6. Хүнсний баталгаат байдал (ХББ)

№	Үзүүлэлт	Тодорхойлолт	Бүгд	Байршил	
				Хот	Хөдөө
1	ХББ дунд зэрэг болон ноцтой байдлаар алдагдсан өрх	ХББ дунд зэрэг болон ноцтой алдагдсан өрхийн хувь	21.6	23.9	16.6
2	ХББ дунд зэрэг алдагдсан өрх	ХББ дунд зэрэг алдагдсан өрхийн хувь	18.9	21.3	13.7
3	ХББ ноцтой алдагдсан өрх	ХББ ноцтой алдагдсан өрхийн хувь	2.7	2.6	2.8

Эх сурвалж: “Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгааны тайлан, 2024

- Хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт/ өвчилсөн хүний тоо


Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтүүд 2021” судалгаанаас харахад, хоол хүнсээр дамжих өвчний дэгдэлт 2019 онд 14 гарч 1288 хүн өвчилсөн бол 2020 онд 12 дэгдэлт гарч, 205 хүн, 2021 онд 5 дэгдэлт гарч, 264 хүн өвчилсөн байна. Нэг өвчний дэгдэлтэд өртсөн хүний тоо 2019 онд 92 байсан бол 2020 онд энэ тоо 17 болж буурсан, 2021 онд 52 болж өссөн байна. Энэхүү үзүүлэлтээр тоон мэдээллийг тогтмол цуглуулж, судалгааг тодорхой давтамжтайгаар хийж байх шаардлагатай.

- Баталгаагүй ундны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаар нөхцөлдсөн нас баралтын түвшин

Эрүүл мэндийн салбарын 2024 оны статистик мэдээллээр Монгол Улсын хүн амын дундах дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос шалтгаалсан нас баралт буюу тухайн кодоор бүртгэгдсэн нас баралтын түвшин тухайн насны 100,000 хүнд 285.4 байгаа нь сүүлийн 10 жилийн дунджаас 27.7-оор, өмнөх оноос 8.5-оор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Баталгаагүй ундны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаас шалтгаалсан нас баралтын түвшинг олон улсын аргачлалын дагуу Өвчний олон улсын ангилал-10 (ӨОУА-10)-д заасан суулгалттай холбоотой A00, A01, A03, A04, A06-A09 кодтой өвчлөл, гэдэсний халдварт B76-B77, B79, хоол, тэжээлийн дутагдалтай холбоотой E40-E46 кодтой өвчлөл, амьсгалын замын цочмог халдварууд J00-J22, нярайн халдвар P23 өвчлөлийг хамруулан тооцоолон гаргахад, 2022 оноос хойш нэмэгдэх хандлагатай байна.


Зураг 19.Баталгаагүй ундны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаар нөхцөлдсөн нас баралтын түвшин /100000 хүнд/



- Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь

Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг 85.0 хувьд хүргэх зорилт тавьсан ба 2021-2025 онд зорилтот түвшиндээ хүрээгүй ч суурь түвшнээс 0.60-1.9 хүртэл хувиар ахисан дүнтэй байна.


Зураг 20.Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь



- Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь

Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 70.0 хувьд хүргэх зорилтыг тавьсан ба 2021-2025 онд зорилтот түвшиндээ хүрээгүй ч суурь түвшнээс 0.29-0.87 хувиар ахисан дүнтэй байна.


Зураг 21. Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь



Хүн амын оршин суух нутаг дэвсгэрийн эрүүл, аюулгүй байдлыг тодорхойлох гол үзүүлэлтийн нэг нь хөрсний бохирдлын асуудал бөгөөд хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн зорилт арга хэмжээний үр дүнг тодорхой шалгуураар тогтмол хэмжиж үнэлж байх шаардлагатай байна. Өнөөдрийн байдлаар хөрсний бохирдлын түвшин, лабораторийн шинжилгээ, хөрсний бохирдлын бууралтыг илэрхийлсэн албан статистик мэдээлэл байхгүй байгаа тул энэ хүрээнд амьдрах орчны эрүүл, баталгаатай байдлын зорилтын хэрэгжилтийг бүрэн тодорхойлж чадахгүй байна.

Үндэсний статистикийн хорооноос 2019 онд баталсан аргачлын дагуу жил бүр хохирол учирсан талбайн хэмжээг газрын үндсэн ангиллаар гаргаж байгаа бөгөөд хот, тосгон, суурин газрын болон усны сав бүхий газрын хохирол учирсан талбайн хэмжээг жил бүр тооцож, мэдээлдэг байна.

Зураг 22.Хот,тосгон, бусад суурин газар болон усны сав бүхий газрын хохирол учирсан талбайн хэмжээ




3.2.6. Хөдөлмөрийн зах зээл

“Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг шинэчилж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох, ажилгүйдлийн даатгалын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр

эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.


Дээрх зорилтын үр дүнг “ажиллах хүчний оролцооны түвшин” болон ажиллагчдын голч цалин, бодит цалингийн индекс үзүүлэлтээр тодорхойлов.

Зураг 23. Ажиллах хүчний оролцооны түвшин



Ажиллах хүчний оролцооны түвшинг 2025 онд 63.0 хувьд хүргэх зорилт тавьсан бөгөөд 2021-2025 онд зорилтот түвшиндээ хүрээгүй, 2021-2023 онд суурь түвшнээс 0.33-2.31 хувиар буурсан байгаа бол 2024-2025 онд суурь түвшнээс 1.32-2.48 хувиар ахисан үзүүлэлттэй байна.

Зураг 24. Ажиллагчдын голч цалин ба бодит цалингийн индекс



3.2.7. Монгол хүний удмын сан

“Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ.” зорилтыг дэвшүүлж, хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг сэргээх, цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлэх, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшинг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлэх, хүн амын удмын сан, нөхөн үржихүйг хамгаалах бодлого, эрх зүйн орчныг бий болгох зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг батлаагүй ба “Угийн бичиг хөтөлдөг өрхийн нийт өрхөд эзлэх хувь” гэсэн шалгуураар хэмжихийг зорьсон ч мэдээллийн дутагдалтай байдлаас шалтгаалан үр дүнг тооцох боломжгүй байна.

Цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлэх, хүн амын удмын сан, нөхөн үржихүйг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Дээрх зорилтын хүрээнд тусгасан хүн, цагаачдын тооны зохист түвшинг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлэх хүрээнд зохист түвшний хязгаарыг алдагдуулахгүй байх, “Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” (isf.mn) системийг нэвтрүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хэрэгжүүлсэн. Монгол Улсад 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 1815 гадаадын иргэн, үүнээс хамгийн их буюу БНХАУ-ын 1226 иргэн цагаачлан оршин суухаар бүртгэлтэй байгаа нь Гадаадын

иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хэмжээнээс хэтрээгүй байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улс нь гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сантай байна гэсний дагуу “Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” (isf.mn) системийг 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, гадаадын иргэний визийн зөвшөөрөл, виз, оршин суухтай холбоотой мэдээллийг бүртгэх, хяналт тавих, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг шуурхай хангах боломжийг бүрдүүлэн холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, уг сангийн мэдээлэлд бүртгэлээр хяналт тавин ажиллаж байна. Цаашид эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тасралтгүй сайжруулах, инновацад суурилсан цахим шинэчлэлийг эрчимжүүлж, технологийн дэвшилд тулгуурласан үйл ажиллагааны дэд бүтцийг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцсэн программ хангамж, хиймэл оюун ухааны технологийг нэвтрүүлж, гадаадын иргэний бүртгэл, хяналт, мэдээллийн тогтолцоог сайжруулах шаардлага байна.

3.3. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА


Монгол хүний амьдралын чанар ба дундаж давхарга бодлогын хүрээнд “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлж, нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл, орлогод нийцсэн орон байр, хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес, дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, газрын харилцаа чиглэлээр 6 зорилт, 27 хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилгын үр дүнг хэмжих 11 шалгуур үзүүлэлт батлагдсанаас 5 үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрч үр дүн гарсан бол 4 үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй, 2 шалгуур үзүүлэлтийг тооцох боломжгүй байна.

Үндэсний статистикийн хорооноос Монгол Улсын ядуурлын түвшний үзүүлэлтийг Дэлхийн банктэй хамтран боловсруулж, хоёр жил тутамд мэдээлдэг ба 2024 оны мэдээлэл гараагүй байна. 2022 оны байдлаар манай улсын нийт хүн амын 914 мянга буюу 27.1 хувь нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй байгаа нь 2020 оны үзүүлэлтээс 0.7 нэгж хувиар буурсан байна. Хөдөөгийн ядуурлын түвшин 2022 онд 5.1 нэгж хувиар өссөн бол нийслэлд 3.8 нэгж хувиар буурч байгаа нь хот, хөдөөгийн ядуурлын түвшний ялгаа нэмэгдэж байгааг харуулж байна.

Ядуурлын үндсэн үзүүлэлтийн хүрээнд нэг хүнд сард ногдох хэрэглээнд үндэслэн тооцсон тэгш бус байдлын үзүүлэлтийг 2 жил тутам тооцдог ба 2024 оны мэдээлэл гараагүй байна. 2022 оны үзүүлэлтээр хэрэглээний тэгш бус байдлын индекс 0.01 нэгжээр буюу хэрэглээний тэнцүү биш байдал 3.1 хувиар буурсан байна.

Зураг 25. Ажилгүйдлийн түвшин



Ажилгүйдлийн түвшинг 2025 онд суурь түвшнээс 22.0 хувиар бууруулж, 7.8 хувьд хүргэх зорилт тавьсан бөгөөд энэхүү зорилтот түвшиндээ хүрч, 2024 оны байдлаар ажилгүйдлийн түвшин 5.9 хувь болсон байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 1212.mn

Үндсэн чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтэд “Дундаж ба түүнээс дээш давхаргын иргэдийн эзлэх хувь” үзүүлэлтийг тусгаж, 2025 онд суурь түвшнээс 11.7 хувиар нэмэгдүүлж, 80.0 хувьд хүргэх зорилтыг тавьсан ч уг үзүүлэлтийг тооцож гаргах аргачлал, мэдээллийн эх сурвалж тодорхой бус байна.

3.3.1. Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл

Энэ хүрээнд “Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ.” зорилтыг дэвшүүлж, даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдүүлэх, иргэн бүрийг нэрийн дансандаа бодит хуримтлалтай болгох, дансны үлдэгдлийн тодорхой хувийг гэр бүлдээ өвлүүлэх нийгмийн даатгалын шинэчлэл хийх, нийгмийн халамж зорилтод бүлэгт хүрч, халамжийн үйлчилгээг ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болгох, хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлэх, нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцийн түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын үр дүнг “Тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт”, “Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ын нийгмийн даатгалд хамрагдсан хувь” гэсэн үзүүлэлтээр хэмжихээр баталсан бөгөөд тэтгэвэр, тэтгэмжийн өсөлтийг 2025 онд 10.0 хувьд хүргэх зорилт тавьж, уг зорилтот түвшиндээ хүрсэн бол эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ын нийгмийн даатгалд хамрагдсан хувь хэмжээг 16.1 хувиар нэмэгдүүлж, 90.0 хувьд хүргэх зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Хүснэгт 7. Нийгмийн хамгаалалтын үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин (2025)	Хүрсэн түвшин			
					2021	2022	2023	2024
1	Тэтгэвэр, тэтгэмжийн өсөлт	хувь	6.0	10.0	1.4	30.8	25.1	12.4
2	Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ын нийгмийн даатгалд хамрагдсан хувь	хувь	77.5	90.0	77.5	77.4	78.0	80.9


Эх сурвалж: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

3.3.2. Орлогод нийцсэн орон байр

Энэ хүрээнд “Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулдаг тогтолцоог бий болгох, үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хэрэгжүүлэх, өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бий болгох, барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын үр дүнг “Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь” үзүүлэлтээр хэмжихээр баталсан ба уг үзүүлэлтийг 2025 онд суурь түвшнээс 30.4 хувиар нэмэгдүүлж, 33.0 хувьд хүргэх зорилт тавьсан. Улсын хэмжээнд 2024 оны байдлаар 996,485 өрх байгаагаас орон сууцанд 385,290 айл өрх амьдарч байна. Үүнээс нийслэлд 231,255 өрх, аймаг орон нутагт 154,035 өрх тус тус амьдарч байгаа нь төлөвлөсөн зорилтот түвшинг хангасан байна.


Зураг 26. Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь



Эх сурвалж: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам

Ипотекийн зээлийн хөтөлбөр нь 2013 онд анх үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж эхэлсэн бөгөөд 7 жилийн хугацаанд буюу 2020 онд ипотекийн зээл авсан иргэдийн тоо 72,128 болсон байна. Энэ тоо 5 жилийн хугацаанд 46,906 зээлдэгч зээл авснаар 119,034 хүрээд байна. Ипотекийн зээлийн санхүүжилт нь ашиглалтад орж буй орон сууцны тоотой шууд хамааралтай байдаг хэдий ч 2022 онд ашиглалтад орсон орон сууцны тоо нэмэгдэхэд зээл авсан тоо, зээлийн хэмжээ өмнөх оноос буурсан байна.

Зураг 27. Ашиглалтад орсон орон сууц, ипотекийн зээл авсан иргэдийн тоо, зээлийн санхүүжилтийн хэмжээ



Эх сурвалж: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам (Монгол банк)

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийслэлийн төвийн төвийн зургаан дүүргийн нутаг дэвсгэрт 2024 оны байдлаар 16 байршил 41 хэсэгчилсэн талбайд 38 төсөл хэрэгжүүлэгч гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 20,247 айлын орон сууц ашиглалтад оруулсан бөгөөд 4384 нэгж талбарын газар чөлөөлөлт хийгдсэн байна.

Бага, дунд орлоготой болон зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцаар хангах зорилтын хүрээнд өнгөрсөн 5 жилийн хугацаанд түрээсийн орон сууц шинээр ашиглалтад ороогүй, 2016 онд “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-д 1520, “Нийслэлийн орон сууцны корпораци” ХК-д 972 айлын орон сууцыг төрийн түрээсийн орон сууцны санд тус тус шилжүүлснээс хойшхи хугацаанд түрээсийн зориулалтаар орон сууц барих, шийдвэрлэх асуудал удаашралтай байна.


3.3.3. Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес

Энэ хүрээнд “Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлэх, бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчныг бэхжүүлэх, малчид, тариаланчдыг бизнесийн тогтвортой орлогын эх үүсвэртэй болгох, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлэх, хоршооны тогтолцоо, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад дорвитой хувь нэмэр оруулах зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.


Дээрх зорилтын үр дүнг өрсөлдөх чадварын үзүүлэлт, бизнес эрхлэлтийн үзүүлэлт, ажиллах хүчний оролцооны түвшин, ажилгүйдлийн түвшин гэсэн шалгуур үзүүлэлтээр хэмжихээр баталсан. Эдгээр шалгуур үзүүлэлтээс ажиллах хүчний оролцооны түвшин, ажилгүйдлийн түвшин үзүүлэлтээр зорилгын үр дүнг хэмжиж тодорхойлсон ба Бизнес эрхлэлтийн үзүүлэлтийн үнэлгээг Дэлхийн банкнаас 2020 оноос хойш хийгээгүй, тайлан гараагүй, аргачлал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор мэдээлэл гарах боломжгүй байна.

Дээрх зорилтын үр дүнг хөдөлмөр эрхлэлтийн түвшин, шинээр бий болсон ажлын байрны тоо, ажилд зуучлагдсан хүний тоо гэсэн шалгуур үзүүлэлтээр авч үзвэл, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2025 онд 2021 оноос 8.3 хувиар, шинээр бий болсон ажлын байрны тоо 12.3 хувиар, ажилд зуучлагдсан хүний тоо 11.9 хувиар тус тус өссөн байгаа нь эерэг үзүүлэлт байна.

Зураг 28. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин



Зураг 29. Шинээр бий болсон ажлын байр



Зорилт 3.3.4. Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлнэ:

“Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлнэ” зорилтын хүрээнд зорилтот санхүүжилт, хөнгөлөлт, хүртээмжтэй үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулах гэсэн хүрэх үр дүнг төлөвлөсөн.


Дээрх зорилтын үр дүнг дотоодын иргэдийн арилжааны үнийн дүнд эзлэх хувь, даатгалын гэрээний тоо, дотоодын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн тоо, хадгаламж зээлийн хоршооны гишүүдийн тоо гэсэн шалгуур үзүүлэлтээр тооцож үзвэл, дотоодын иргэдийн арилжааны үнийн дүнд эзлэх хувь 2025 онд 2021 оны түвшнээс 62.8 хувиар, даатгалын гэрээний тоо 32.5 хувиар, дотоодын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн тоо 12 нэгжээр, хадгаламж зээлийн хоршооны гишүүдийн тоо 1.96 хувиар нэмэгдсэн байна.

2021 оноос 2025 оны хоёрдугаар улирал хүртэлх хугацаанд хоёрдогч зах зээлийн дотоодын иргэдийн арилжааны эзлэх хувь тогтвортой өсөлт үзүүлж байна. Тухайлбал, дотоодын хөрөнгө оруулагчдын гүйлгээний эзлэх хувь 24.2 хувиас 39.42 хувьд хүрсэн нь зах зээлд иргэдийн оролцоо нэмэгдсэн, хөрөнгө оруулалтын идэвх сэргэж байгааг илтгэж байна. Мөн тайлант хугацааны эхэнд буюу 2021 онд хоёрдогч зах зээлийн арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа нийт арилжааны 24.2 хувийг эзэлж байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар дотоодын иргэний хийсэн арилжаа 170.05 тэрбум төгрөг буюу нийт гүйлгээний 31.61 хувийг, 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 82.82 тэрбум төгрөг буюу нийт гүйлгээний 39.42 хувийг тус тус эзэлж байна. Эдгээр тоон үзүүлэлтүүд нь үнэт цаасны компаниуд цахим болон дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлж, хөрөнгө оруулагчдын зах зээлд оролцох нөхцөлийг хялбаршуулсан, мөн сурталчилгаа, боловсрол, зөвлөмжийн үйлчилгээ сайжирсантай шууд холбоотой байна. Үүнээс гадна иргэдийн санхүүгийн мэдлэг нэмэгдэж, хөрөнгө оруулалтын идэвх эрс нэмэгдсэн нь дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоо тогтмол өсөхөд нөлөөлсөн байна.

Хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хүрээнд “Хүнсний хувьсгал”, “Шинэ хоршоо-чинээлэг малчин”, “Цагаан алт”, “Атар-4” үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Ковид-19, геополитикийн нөлөөгөөр үүссэн хүнсний хомсдолыг бууруулж, дотоодын хэрэгцээг бүрэн хангах зорилгоор хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрүүдийг Монголбанк, арилжааны банкуудын дэмжлэгтэйгээр төсөвт ачаалал үүсгэлгүй хэрэгжүүлж байгаа бөгөөд Засгийн газар зээлийн хүүгийн тодорхой хувийг хариуцан төлж байна. 2023–2024 онд “Хүнсний хувьсгал” хөтөлбөрөөр 1.26 их наяд төгрөгийн зээлийг 3,154 иргэн, аж ахуйн нэгжид олгож, 165.7 тэрбум төгрөгийн хүүгийн дэмжлэг үзүүлжээ. “Шинэ хоршоо-чинээлэг малчин” хөтөлбөрөөр 769.5 тэрбум төгрөгийн зээл 22.7 мянган малчинд олгож, 6,469 хоршоо шинээр байгуулагдсан. Засгийн газар 2025 оны төсөвт 105.3 тэрбум төгрөгийн хүүгийн дэмжлэг тусгажээ. “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд ноос, ноолуур, арьс ширний эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд 1.5 их наяд төгрөгийн зээлийг олгохоор төлөвлөж, 66.3 тэрбум төгрөгийг хүүгийн дэмжлэгт тусгасан. “Атар-4” аяны хүрээнд 2025 онд газар тариалангийн салбарт 800 тэрбум төгрөгийн зээл олгож, 52.8 тэрбум төгрөгийг хүүгийн дэмжлэгт зарцуулах юм. Эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд 2023–2024 онд нийт 2.17 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр олгоод байна.

Энэ зорилтын хүрээнд Зээлийн хүүг бууруулах стратегийг УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дугаартай тогтоолоор батлан, Монгол Улсын Засгийн газар, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран хэрэгжүүлж, стратегийн хэрэгжилтийг хагас жил тутам тайлагнан ажиллаж байна. Тус стратегийн баримт бичиг нь 4 заалт, 4 дэд заалтын хүрээнд тодорхойлсон 19 арга хэмжээ, 47 дэд арга хэмжээнээс бүрдсэн бөгөөд дараах үндсэн 4 чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд: зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро эдийн засгийн тогтвортой орчин бүрдүүлэх; зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах; банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах; хөрөнгийн захыг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах зэрэг байна. Монголбанкнаас ковид-19 цар тахлын үед нийгэм, эдийн засагт тулгарч буй санхүүгийн хүндрэл, дарамтыг зөөлрүүлэх, эдийн засгийн сэргэлтийг дэмжих ажлын хүрээнд бодлогын хүүг 2020 онд 5 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэсэн байна.

Зураг 30. Санхүү, даатгалын салбарын үзүүлэлт




ДНБ-д санхүү, даатгалын үйл ажиллагааны салбарын эзлэх хувь 2020 онд 4.7 хувь байсан бол 2024 онд 5.2 хувь болж, 0.5 нэгж хувиар өссөн нь санхүү, даатгалын салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр бага боловч өсөлт бага боловч тогтвортой эерэг чиг хандлагатай байгаа нь салбарын эдийн засагт үзүүлэх хувь нэмэр нэмэгдэж байгааг илтгэж байна. 2020 онтой харьцуулахад 2024 онд төгрөгийн зээлийн хүү бага зэрэг өсөж, валютын зээлийн хүү мэдэгдэхүйц буурсан байна.

3.3.5. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

Энэ хүрээнд “Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлэх, иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх, нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлэх, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилтыг дээшлүүлэх, хоол, хүнсний тухай боловсрол олгох талаар сургалтын хөтөлбөрт тусгах зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн. Зорилтын үр дүнг “Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт” шалгуур үзүүлэлтээр хэмжихээр баталсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу Монгол Улсын хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг жил бүрийн дөрөвдүгээр сард явуулж байна. Сорилд хамрагдах иргэдийн тоо жил бүр нэмэгдэж, А,В,С үнэлгээтэй иргэдийн эзлэх хувь 67.7-79.2 хувьтай байна.

Зураг 31. Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт



Иргэд, албан хаагчид бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдсанаар хувь хүн, хамт олон өөрийн бие бялдар, эрүүл мэндээ хянах үндэс суурь тавигдах төдийгүй аливаа өвчлөл, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх үндэс болно.

Эх сурвалж: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам


Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих хүрээнд биеийн тамир, спортын заал, талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай бөгөөд 2021-2024 онд спорт заал 179 буюу 11.5 хувиар, гадаа талбай 268 буюу 17.1 хувиар тус тус нэмэгдсэн байна.

3.4.ЭДИЙН ЗАСАГ

Энэ хүрээнд “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно” гэсэн зорилгыг дэвшүүлж, чинээлэг монгол, эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд, ухаалаг санхүүгийн зээл, бүс нутгийн хамтын ажиллагаа, өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн, үндэсний баялгийн сан гэсэн чиглэлээр 6 зорилт, 35 хүрэх үр дүнг төлөвлөсөн. Зорилго, зорилтын үр дүнг хэмжих 14 шалгуур үзүүлэлтийг баталсан ба эдгээрийн 42.9 хувь нь зорилтот түвшинг 85.0 дээш хувиар хангасан бол 57.1 хувь нь 85.0 хувиас бага буюу үр дүнгүй үнэлэгдсэн байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүнийг 2025 онд суурь түвшнээс 84.4 хувиар нэмэгдүүлэх зорилт тавьсан ба 2021-2024 онд тогтмол өсөлттэй байж, 2024 онд 23.6 тэрбум ам.долларт хүрсэн нь зорилтот түвшинг 85.0 дээш хувиар хангасан байна.

Зураг 32.Дотоодын нийт бүтээгдэхүүн (тэрбум ам.дол)



Хүснэгт 8. Дотоодын нийт бүтээгдэхүүний үзүүлэлт (нэг хүнд ногдох, ДНБ өсөлт бууралт)

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжиг х нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин				
					2020	2021	2022	2023	2024
1	Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ	ам.дол	4,050	6,520	4,128	4,657	5,126	6,008	6,898
2	ДНБ-ний жилийн цэвэр өсөлт, бууралт	хувь			(4.6)	1.6	5.0	7.4	4.9

3.4.1.Чинээлэг Монгол

Энэ хүрээнд “Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлж, Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, өрийн дарамтыг бууруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөлийг бүрдүүлэх, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болгох, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлтийг тасралтгүй нэмэгдүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлэх гэсэн хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Хүснэгт 9.Эдийн засгийн тогтвортой байдал


Он	2020	2021	2022	2023	2024
ДНБ-ий жилийн өсөлт (хувь)	-4.6	1.6	5.0	7.4	4.9
Гадаад валютын улсын нөөц (сая ам.доллар)	786.9	-224.9	-750.9	1398	539.8

ДНБ-ийн жилийн өсөлт 2020 онд -4.6 хувь буюу гүн уналттай байсан бол 2024 онд 4.9 хувийн эерэг өсөлттэй болж, нийтдээ 9.5 нэгж хувиар дээшилжээ. Энэ нь цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт бодитой болсон, үйлдвэрлэл, үйлчилгээний салбар идэвхжсэн, дотоодын хэрэглээ болон экспорт өссөнтэй холбоотой юм. Ийнхүү 2020 оны уналтаас дөрвөн жилийн дотор тогтвортой өсөлтөд шилжсэн нь макро эдийн засгийн орчин сайжирсны тод жишээ болж байна.

Нөгөө талаас, гадаад валютын улсын нөөцийн өөрчлөлтийг авч үзвэл, 2020 онд 786.9 сая ам.доллараар нэмэгдэж байсан бол 2024 онд 539.8 сая ам.доллараар өссөн байна. Хэдийгээр нэмэгдлийн хэмжээ 2020 оныхоос бага боловч, 2021–2022 онд огцом буурсан дарамтаас гарч, тогтвортой өсөлт рүү шилжсэн нь эерэг үзүүлэлт юм. Энэ нь гадаад худалдааны нөхцөл сайжирч, төлбөрийн тэнцэл харьцангуй эерэг чиглэлд орсныг илтгэнэ.

Ерөнхийд нь харвал, 2020 онд эдийн засаг уналттай, валютын нөөцийн савлагаатай байсан бол 2024 онд эдийн засаг тогтвортой өсөлттэй, валютын нөөц нэмэгдэж буй эерэг төлөв бий болсон байна.

Зураг 33. Өрийн дарамт



Монгол Улсын нийт гадаад өр 2024 оны эцэст 37.2 тэрбум ам.долларт хүрч, 2020 оноос 4.9 тэрбум ам.доллар буюу 15.1 хувиар, өмнөх оноос 2.7 тэрбум ам.доллар буюу 7.7 хувиар тус тус өссөн байна. Засгийн газрын нийт өр 2024 оны эцэст 33.4 их наяд төгрөгт хүрч, 2020 оноос 5.5 их наяд төгрөг буюу 19.7 хувиар, өмнөх оноос 2.6 их наяд төгрөг буюу 8.5 хувиар тус тус өссөн байна.


Монгол Улсын эдийн засаг 2020 онд ковид-19 цар тахлын сөрөг нөлөөнд орж, ДНБ 13.3 тэрбум ам.долларт хүрсэн бол нийт гадаад өр 32.4 тэрбум ам.долларт хүрсэн нь тухайн үеийн ДНБ-ий 243.6 хувьтай тэнцэж байв. Энэ нь эдийн засгийн хүчин чадалд харьцуулахад өрийн дарамт маш өндөр байсныг илэрхийлнэ. Ийм нөхцөлд макро эдийн засгийн тогтвортой байдал алдагдах өндөр эрсдэлтэй байсан бөгөөд валютын нөөц багасах, төлбөрийн тэнцлийн хүндрэл үүсэх зэрэг сорилт гарч байв.

Харин 2024 он гэхэд ДНБ 23.6 тэрбум ам.доллар болж, дөрвөн жилийн хугацаанд 10.3 тэрбум ам.доллараар буюу бараг хоёр дахин өссөн нь эдийн засгийн сэргэлт, өсөлт тогтвортой үргэлжилснийг харуулж байна. Үүний зэрэгцээ нийт гадаад өр 37.2 тэрбум ам.доллар болж нэрлэсэн дүнгээр өссөн боловч өрийн дарамт харьцангуй буурч, ДНБ-д эзлэх хувь нь 157.6 хувь болж буурсан байна. Энэ нь 2020 онтой харьцуулахад өрийн дарамт 86 нэгж хувиар багассан томоохон өөрчлөлт юм.

Монгол Улсын ДНБ 2024 онд 2020 онтой харьцуулахад бараг хоёр дахин өсөж, гадаад өрийн хэмжээ нэрлэсэн утгаараа нэмэгдсэн боловч эдийн засгийн өсөлт илүү хурдтай байсан учир өрийн дарамт мэдэгдэхүйц буурсан байна. Энэ нь макро эдийн

засгийн тогтвортой байдлыг хадгалах, өрийн тогтвортой удирдлагын чухлыг харуулж байна.

Зураг 34. Эдийн засгийн эрх чөлөөний индекс



Монгол Улсын 2024 оны Эдийн засгийн эрх чөлөөний индексийн харьцангуй өндөр оноотой үзүүлэлтүүд нь худалдааны эрх чөлөө (74.4), мөнгөний эрх чөлөө (67.9), хөдөлмөрийн эрх чөлөө (67.5), бизнесийн эрх чөлөө (68.0) байна.

Энэ нь Монголын эдийн засагт зах зээлийн харьцангуй чөлөөтэй орчин бүрдэж, бизнесийн үйл ажиллагаа явуулах боломж тодорхой хэмжээнд нээлттэй байгааг харуулж байна. Худалдааны эрх чөлөөний өндөр оноо нь гадаад худалдааны бодлого харьцангуй нээлттэй, тарифын түвшин тогтвортой байгаагийн илрэл бол бизнесийн эрх чөлөө болон хөдөлмөрийн эрх чөлөө нь дотоодын бизнес эрхлэгчид зах зээлийн боломжийг ашиглах нөхцөл бүрдсэнтэй холбоотой гэж дүгнэж болно.

Санхүүгийн эрх чөлөө (50.0) болон хөрөнгө оруулалтын эрх чөлөө (50.0) нь дунд түвшинд байна. Энэ нь Монголын хөрөнгийн зах зээл хөгжлийн шатандаа бүрэн бэхжиж чадаагүй, банк санхүүгийн тогтолцоо зах зээлийн өрсөлдөөн хангалттай бус, гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан эрх зүйн баталгааны тогтвортой байдал сул байгааг харуулдаг. Ингэснээр эдийн засгийн гадаад эх үүсвэр татах, хөрөнгө оруулалтын орчныг тогтвортой байлгах тал дээр тодорхой эрсдэлтэй хэвээр байна.

Өмчийн эрх (48.8), шүүхийн үр нөлөө (34.8), Засгийн газрын шударга байдал (48.4) зэрэг хууль эрх зүйн орчинтой холбоотой үзүүлэлтүүдийн сул оноо юм.

Өмчийн эрх хангалттай хамгаалагдахгүй, шүүхийн хараат бус байдал болон үр нөлөө сул байгаа нь бизнесийн орчны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг. Засгийн газрын шударга байдлын бага оноо нь авлигын түвшин өндөр байгаагийн илрэл бөгөөд эдгээр нь эдийн засгийн эрх чөлөөний өсөлтөд үндсэн саад болж байна.

3.4.2. Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд

“Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, мэдээллийн технологи, зам тээвэр, эрчим хүчний салбарын хүрээний 13 хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд дээрх зорилтын үр дүнг салбарын 6 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр баталсан ба 1 шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн бол 5 шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Хүснэгт 10. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин (2025)	Хүрсэн түвшин				
					2020	2021	2022	2023	2024
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь			12.8	13.0	12.8	9.8	7.3
2	Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	24.3	30.6	24.1	25.4	23.6	28.7	27.9
3	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	10.9	12.0	9.2	8.5	8.6	7.3	6.7
4	Тээвэр агуулахын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	4.6	5.1	3.6	3.8	4.8	5.6	5.8
5	Мэдээлэл, холбооны салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь			2.2	2.4	2.3	2.1	2.2


Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2025 онд суурь түвшнээс 25.9 хувиар өсгөж, 30.6 хувьд хүргэхээр, боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг суурь түвшнээс 10.1 хувиар нэмэгдүүлж, 12.0 хувьд хүргэхээр төлөвлөсөн ч зорилтот түвшиндээ хүрээгүй бол тээвэр агуулахын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 10.9 хувиар нэмэгдүүлж, 5.1 хувьд хүргэх зорилт үр дүндээ хүрсэн байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 6 сарын байдлаар 18.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 532.0 (2.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 13.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.1 (7.5%) их наяд төгрөгөөр буурахад нүүрс олборлолт 2.4 (27.1%) их наяд төгрөгөөр, газрын түүхий тосны олборлолт 78.9 (13.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Хөдөө аж ахуйн салбарын дотоод нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2021-2024 онд 0.2-3.0 хүртэл хувиар буурсан нь цаг агаарын нөхцөл байдал хүндэрч, малын тоо толгой буурсан, том малын зүй бус хорогдол нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна.


Хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны нийт махны хэрэглээнд эзлэх хувийг 2025 онд суурь түвшнээс 57.7 хувиар нэмэгдүүлж, 50.0 хувьд хүргэх, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүний нийт сүүний хэрэглээнд эзлэх хувийг суурь түвшнээс 101.3 хувиар нэмэгдүүлж, 30.0 хувьд хүргэх зорилт тавьсан.

Зураг 35. Хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, сүүний нийт хэрэглээнд эзлэх хувь



Экспорт: Монгол Улсын нийт экспортын хэмжээг 2025 онд суурь түвшнээс 100 хувь нэмэгдүүлж, 14,020.0 сая ам.долларт хүргэх зорилт тавьж, экспортыг нэмэгдүүлэх тодорхой бодлого, арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд 2024 онд экспортын нийт хэмжээ суурь түвшнээс 125.1 хувиар өсч, төлөвлөсөн зорилтот түвшиндээ хүрсэн байна.

Зураг 36. Экспорт (сая ам.дол)



Монгол Улсын 2024 оны гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.4 тэрбум ам.доллар болж, экспорт 15.8 тэрбум ам.доллар, импорт 11.6 тэрбум ам.долларт хүрчээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ 2020 оноос 14.5 (2.1 дахин) тэрбум ам.доллар, экспорт 8.2 (2.1 дахин) тэрбум ам.доллараар, импорт 6.3 (2.2 дахин) тэрбум ам.доллараар, өмнөх оноос нийт бараа эргэлтийн хэмжээ 3.0 (12.1%) тэрбум ам.доллар, экспорт 596.5 (3.9%) сая ам.доллараар, импорт 2.4 (25.6%) сая ам.доллараар тус тус өссөн байна. 2025 оны 7 дугаар сарын байдлаар экспорт 7,752 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 16 хувиар буурсан байна.


Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын нийт экспорт 2024 оны гүйцэтгэлээр 786.3 сая ам.долларт хүрч, 2022 онтой харьцуулахад 13.9 хувиар өссөн байна. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын экспортын бүтцийг авч үзвэл, экспортын барааны нийт дүнд нэхмэл, хувцас үйлдвэрлэл, мах, махан бүтээгдэхүүн, түүхий эдийн экспорт дийлэнх хувийг эзэлж байна. 2024 оны дүнгээр нэхмэл,

нэхмэлийн бүтээгдэхүүний экспорт 451.2 сая ам.доллар мах, махан бүтээгдэхүүний экспорт 285.4 сая.ам.доллар болсон байна.

Өрсөлдөх чадварын үзүүлэлт: Өрсөлдөх чадварыг тодорхойлох судалгаагаар тухайн улс, бүс нутаг өөрийн нөөц боломжоо хэрхэн үр дүнтэй ашиглаж, өөрийн гэсэн өрсөлдөх чадварыг бий болгож, амьдрах болоод бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж чадсан эсэхийг тодорхойлдог. /IMD/ Дэлхийн өрсөлдөх чадварын төв 1988 оноос хойш “Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан”-г гаргаж байгаа бөгөөд одоогоор 63 улсын өрсөлдөх чадварыг 4 үндсэн бүлэг бүхий 261 үзүүлэлтээр хэмждэг.

Монгол Улс Дэлхийн өрсөлдөх чадварын төвийн судалгаанд жил бүр хамрагддаг бөгөөд энэхүү үзүүлэлтийг 2025 онд суурь түвшнээс 10.3 хувиар нэмэгдүүлж, 58-д хүргэх зорилт тавьсан.

Зураг 37. Өрсөлдөх чадварын үзүүлэлт (оноогоор)



Эх сурвалж: International Institute for Management Development, World Competitiveness Booklet

Дэлхийн өрсөлдөх чадварын тайлангийн үр дүнгээс харахад, Монгол Улс 2019 оноос 2023 он хүртэл өрсөлдөх чадварын үзүүлэлт буурч байсан ба 2024 онд өмнөх оноос 30.1 хувиар өссөн ч 2025 онд эргээд буурч авбал зохих 100 онооноос 40.9 оноо авч, харьцуулах боломжтой, сонгогдсон 69 улсаас 65 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Энэ үзүүлэлт өмнөх оныхоос 11.7 хувиар, суурь түвшнээс 22.2 хувиар буурсан байна.

Дээрх зорилтын хүрээнд гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувийг 80 хувьд хүргэхээр төлөвлөсөн ч цар тахлын нөлөөгөөр ЕРС-2, ЕРС-3 багцуудын тендер шалгаруулалт 14 хүртэл сараар хойшилсон, бүтээн байгуулалтын ажил удааширч улмаар гэрээний үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор шийдвэрлэх, түүнчлэн ЕРС-4 багцын санхүүжилтийг БНЭУ-ын ЭкСим банк 2024.11 сард шийдвэрлэсэн зэрэгтэй холбоотойгоор төслийн ажил удааширч, төлөвлөсөн үр дүндээ хүрэх боломжгүй байна.

3.4.3. Ухаалаг санхүүгийн зах зээл

“Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөж, биржийн бус болон үүсмэл санхүүгийн зах зээл дээр хийгдэж байгаа арилжааны дүнг өсгөх, даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах хууль, эрх зүйн орчин бүрдэж, салбарын хамрах хүрээг нэмэгдүүлэх, бичил санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулан эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулж, үйл ажиллагааны хүрээг тэлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгох, банк санхүүгийн зах зээлийн эрсдэл даах, найдвартай байдлыг хангах зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.


Энэ зорилтын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тогтвортой хөгжлийн зорилтыг ханган хэрэгжүүлэх арга хэмжээ нь нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой байгаа тул Засгийн газрын зүгээс Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу эцэслэн боловсруулж 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан. Түүнчлэн санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх, салбарын мэргэжлийн оролцогчдын чадавх, салбарын зах зээлд эзлэх хувь хэмжээ, дотоодын давхар даатгалын эрсдэл даах чадавхыг тус тус нэмэгдүүлэх замаар гадагш чиглэсэн валютын урсгалыг бууруулах, цаашлаад олон улсад өрсөлдөх чадамжтай даатгалын зах зээлийн бүрдүүлэх зорилгоор Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Даатгалын мэргэжлийн оролцогчдын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Жолоочийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулж 2025 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барихаар төлөвлөн ажиллаж байна.

Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 265 дугаар тогтоолоор батлагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн 5.4 дэх хэсэгт Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан ажлын биелэлт, явцын тайланг улирал бүр тайлагнахаар заасны дагуу Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, ММНБИ тайланг нэгтгэн, Санхүүгийн мэдээллийн албанд цахим хэлбэрээр шаардлагатай тохиолдолд албан бичгээр тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн А122/А-172 дугаар хамтарсан тушаалаар “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”-ыг баталсан. Тус журам батлагдсанаар банкинд төсвийн байгууллага данс нээхэд банк нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол хангасан байх, тус банкин дахь төрийн хөрөнгө нийт хөрөнгийн 30 хувиас ихгүй байх шаардлагыг хангасан байх болон данс нээсний дараа тогтмол хяналт тавих зохицуулалт зэргийг тусгасан.

Зураг 38.Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, хөдөө аж ахуйн биржийн арилжаа



Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2021 онд 3.8 их наяд төгрөг байсан бол 2024 онд 11.3 их наяд төгрөг болж, ойролцоогоор 3 дахин өссөн байна. Гэвч хөрвөх чадвар 3.1-ээс 1.4 болж буурсан, зах зээл тэлж байгаа ч идэвх, эргэлтийн чадвар сул байгааг илтгэж байна.

Хөдөө аж ахуйн биржийн арилжаа 2020 онд 488.7 тэрбум төгрөг байсан арилжаа 2024 онд 995.9 тэрбум төгрөг болж, 2 дахин нэмэгдсэн нь зах зээл өргөжиж, бүтээгдэхүүний арилжааны хэмжээ нэмэгдсэнийг харуулж байна.

Даатгалын хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь буюу даатгалын гүнзгийрэлт 2020 онд 0.57 хувь байсан бол 2024 онд 0.60 хувь болж, бага зэрэг өссөн. Энэ салбарын хамрах хүрээ ахицтай боловч өсөлт нь удаан байна.

2020 оноос 2024 он хүртэлх хугацаанд Монгол Улсын хөрөнгийн зах зээл болон хөдөө аж ахуйн биржийн арилжаа эрс тэлсэн нь санхүүгийн зах зээл өргөжиж байгааг харуулж байна.

3.4.4. Бүс нутгийн хамтын ажиллагаа

“Хөрш орнуудтай хамтран эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Евразийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Солонгос Улстай чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулах эсэх талаар урьдчилсан судалгааг эхлүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын эдийн засгийн коридорыг хөгжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх, Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх бэлтгэл ажлыг хангаж, худалдааг хөнгөвчлөх, экспортыг дэмжих, худалдааг хөнгөвчлөхөд стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогоор дэмжлэг үзүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн. Дээрх зорилтын үр дүнг хэмжих тодорхой шалгуур үзүүлэлт батлагдаагүй.


Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын Худалдааны түр хэлэлцээрийн албан ёсны яриа хэлэлцээ 2023 оноос эхэлсэн бөгөөд 2025 оны хоёрдугаар хагаст байдлаар гурван шатны хэлэлцээг амжилттай зохион байгуулж, хэлэлцээрийн хүрээнд импортын татвараас чөлөөлөх хоёр талын барааны жагсаалтыг эцэслэн тохиролцсон бөгөөд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн. Хоёр дахь шатны хэлэлцээг 2024 оны 09 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо, гурав дахь шатны хэлэлцээг 2025 оны 03 дугаар сарын 18-22-ны өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо тус тус зохион байгуулсан. Барааны жагсаалтаар 2 талаас ижил тооны буюу БТКУС-ын 6 оронтой кодоор 367 нэр төрлийн бараанд тарифыг шууд тэглэх, тохирсон квотын хэмжээнд тарифыг тэглэх болон тохирсон квотын хэмжээнд тарифын хөнгөлөлт эдлэх гэсэн үндсэн 3 төрлөөр тарифын саад тогторыг бууруулахаар тохиролцсон.

Мөн энэ онд "Монгол Улс, Евроазийн эдийн засгийн холбоо хоорондын түр хэлэлцээр"-т гарын үсэг зурж, Монголын үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдэд ОХУ, Беларусь, Казахстан, Киргиз, Армени улсуудад гаалийн татваргүй 367 төрлийн бараа бараа бүтээгдэхүүн экспортлох боломжийг бүрдүүлсэн байна.

3.4.5. Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн

“Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацад тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан, гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх гэсэн хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Зураг 39. Жижиг, дунд үйлдвэрлэл



Жижиг, дунд үйлдвэрлэлийн үзүүлэлтүүдийг харьцуулахад, суурь түвшинд (2019–2020) экспортын дүнд эзлэх хувь 3.4 хувь, дотоодын нийт бүтээмжид эзлэх хувь 5.6 хувь, ашигтай загварын гэрчилгээ 19 байсан бол 2023 онд экспорт 1.7 хувь болж буурч, дотоод бүтээмж 6.2 хувь хүртэл өссөн, мөн 44 ашигтай загварын гэрчилгээ олгогдсон байна. Харин 2025 онд экспорт болон дотоодын бүтээмжийн үзүүлэлт Үндэсний статистикийн хорооны цахим хуудсанд бүртгэлгүй болж, ашигтай загварын гэрчилгээ 34 болж 2023 оноос 10-аар буурсан ч суурь түвшнээс 1.8 дахин өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь жижиг, дунд үйлдвэрлэлийн экспортын өрсөлдөх чадвар буурч, дотоодын бүтээмжийн хэмжилт тогтворгүй болсон боловч инноваци, шинэ бүтээлийн үйл ажиллагаа суурь түвшнээс тогтвортой дээшилж буйг харуулж байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн экспорт болон бүтээмжид эзлэх хувь 2023 он хүртэл тодорхой хэмжээнд хадгалагдсан байна. Харин инновацийн үзүүлэлт болох ашигтай загварын гэрчилгээ олголт суурь түвшнээс хойш тогтвортой өсөлттэй байсан боловч 2023 оноос хойш бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна. Иймд жижиг, дунд үйлдвэрлэлийн экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, дотоод бүтээмжийн хэмжилтийг тогтвортой үргэлжлүүлэх, инновацийн үйл ажиллагааг тасралтгүй дэмжих шаардлагатай байна.

3.5.3 АСАГЛАЛ

Засаглалын бодлогын хүрээнд “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” гэсэн зорилгыг дэвшүүлж, ухаалаг засаглал, ухаалаг бүтэц, цахим монгол, чадварлаг, ёс зүйтэй төрийн алба, хүний эрхийг дээдэлсэн нийгэм, авлигагүй засаглал гэсэн чиглэлийн хүрээнд 6 зорилт, 25 хүрэх үр дүнг төлөвлөсөн.


Дээрх зорилгын хэрэгжилтийг Дэлхийн банкнаас жил бүр тооцож боловсруулдаг засаглалын үзүүлэлтүүд болох Засгийн газрын үр нөлөө, Зохицуулалтын чанар, Хуулийн засаглал, Иргэдийн дуу хоолой ба хариуцлага, Авлигын хяналт, Цахим засгийн хөгжлийн үзүүлэлт, олон улсын түвшинд нийцүүлж шинэчилсэн үндэсний стандартын тоо зэрэг үндэсний үр дүнгийн үзүүлэлтээр хэмжихээр баталсан.

3.5.1. Ухаалаг засаглал

“Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд эрх мэдлийг тэнцвэржүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулах, Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа тогтвортой, залгамж чанартай, үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдүүлэх, нийгэм, эдийн засаг, бизнесийн бүхий л харилцаа, засаглалын бүх шатанд олон талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлэх, XXI зууны төрийн удирдлагын шинэ арга барил болох гурван тулгуурт хөгжлийн онолын дагуу улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн бүхий л харилцаа, засаглалын бүх шатанд гурван талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн Хуулийн засаглал үзүүлэлт нь нийгмийн дүрэм журмыг сахих итгэл үнэмшлийн хэр хэмжээ, гэрээний хэрэгжилт, өмчлөх эрх, цагдаа болон шүүхийн чанар, гэмт хэрэг, хүчирхийлэл гарах магадлалыг тооцож авч үздэг бөгөөд манай улс 2025 онд суурь түвшнээс 14.5 хувиар өсгөж, 51.2 хувьд хүргэх зорилт биелээгүй, зорилтын үр дүнг 1.4 хувиар хангасан байна. 2023 оны үнэлгээ 43.87 хувь байгаа нь өмнөх оноос 4.1 хувиар, суурь түвшнээс 1.9 хувиар тус тус буурсан байна.

Зураг 40. Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Хуулийн засаглал




3.5.2. Ухаалаг бүтэц

“Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог бий болгоно.” зорилтыг дэвшүүлж, төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах шинэчлэл хийх, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, хувийн өмчийг хамгаалах эрх зүйн оновчтой зохицуулалт хийх, адаад хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэг цонхны нэгдмэл бодлого хэрэгжүүлж хэвшүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Энэхүү зорилтын үр дүнг Дэлхийн банкны засаглалын “Зохицуулалтын чанар” үзүүлэлтээр хэмжиж үнэлэхэд, 2025 онд суурь түвшнээс 18.4 хувиар өсгөж, 64.9 хувьд хүргэх зорилт тавьсан бөгөөд 2023 оны үнэлгээ 45.75 хувь байгаа нь өмнөх оноос 7.8 хувиар өссөн ч суурь түвшнээс 16.5 хувиар буурсан байна.

Зураг 41. Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Зохицуулалтын чанар




Зохицуулалт чанар үзүүлэлт нь Засгийн газрын зөв бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чадвар болон хувийн хэвшлийн дэмжих, эрх зүйн таатай орчин, зах зээлийн чөлөөт эдийн засагт харшлах арга хэмжээтэй холбоотой асуудлуудыг авч үзэж үнэлдэг.

3.5.3. Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)

“Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж, хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбох, цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болгож хөгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлттэй болох, төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоог сайжруулж, захиргааны зардлыг бууруулах, үйлчилгээний үр дүнг сайжруулах, төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Энэхүү зорилтын үр дүнг Цахим засаглалын хөгжлийн үзүүлэлт болон Харилцаа холбоо дэд бүтцийн индекс, Цахим үйлчилгээний индекс үзүүлэлтээр тооцож үнэлэхэд, Цахим засаглалын хөгжлийн үзүүлэлтийг 2025 онд суурь түвшнээс 9.2 хувиар өсгөж, 0.6358 нэгжид хүргэх зорилт тавьсан бөгөөд 2024 оны үнэлгээ 0.8457 байгаа нь өмнөх оноос 17.3 хувиар, суурь түвшнээс 45.2 хувиар өсч, төлөвлөсөн зорилтот түвшиндээ хүрсэн байна.

Зураг 42. Цахим засгийн хөгжлийн үзүүлэлт



НҮБ-ын Цахим засаглалын хөгжлийн индекс (EGDI)-ийн гурван бүрэлдэхүүн хэсгийн нэг нь харилцаа холбоо, дэд бүтцийн индекс бөгөөд 2024 оны байдлаар дэлхийн дундаж 0.68 байна.

Манай улс энэ үзүүлэлтээр 2022 онд 0.7 оноо авч байсан бол 0.9 оноогоор үнэлэгдэж, 28.6 хувийн ахицтай байна.

Цахим үйлчилгээний индекс нь мөн Цахим засаглалын хөгжлийн индексийн

нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд 2024 оны байдлаар дэлхийн дундаж 0.57 байгаа бол манай улсын хувьд 2022 онд 0.6 оноо, 2024 онд 0.8 оноогоор үнэлэгдэж, дунджаас дээгүүр байна.


3.5.4 Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба

“Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд чадахуйн зарчимд суурилсан, мэргэшсэн төрийн алба төлөвшүүлэх, сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн албан хаагч тогтвортой ажиллах нөхцөл бүрдэж, төрийн албаны шатлан дэвшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлэх, төрийн үйлчилгээний чанарын стандарт бий болж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлэх, төрийн үйл ажиллагааны бүхий л шатанд Шилэн дансны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах замаар иргэдийн мэдээлэл авах эрхийг дээдлэн ажиллаж, холбогдох хуулийн дагуу иргэний шаардсан мэдээллийг гаргаж өгөөгүй төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын удирдлагад хариуцлага тооцдог болох, орон нутагт томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг сайжруулах зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Энэхүү зорилтын үр дүнг Дэлхийн банкны засаглалын “Засгийн газрын үр нөлөө” үзүүлэлтээр хэмжиж үнэлэхэд, 2025 онд суурь түвшнээс 18.8 хувиар өсгөж, 54.3 хувьд

хүргэх зорилт төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна. 2023 оны үнэлгээ 33.96 хувь байгаа нь өмнөх оноос 2.7 хувиар, суурь түвшнээс 25.7 хувиар буурсан байна.

Зураг 43. Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Засгийн газрын үр нөлөө



Энэхүү үзүүлэлт нь төрийн үйлчилгээ, төрийн албаны чанар, түүний улс төрийн нөлөөллөөс ангид байгаа эсэх, бодлого боловсруулалт, хэрэгжилтийн чанар, Засгийн газрын бодлогод тавих хяналт, хариуцлагын асуудлыг авч үздэг.


Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно.” гэж, 26 дугаар зүйлийн 26.1-д Төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 3.1.3-т заасан чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилно.” гэж тус тус заасны дагуу хуулиар тогтоосон шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж томилох асуудалд зөрчил байсаар байгаа нь мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлэхэд ихээхэн саад болж байна. Төрийн албаны зөвлөлийн 2019-2023 онд төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтад нийт 720 байгууллага, 12113 албан хаагч хамрагдсанаас 780 албан хаагчийн томилгоог хууль тогтоомж зөрчиж хийсэн байна. Энэ нь нийт шалгалтад хамрагдсан албан хаагчдын 6.4 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ хувь 2020 онд өмнөх оноос 15.0 нэгж хувиар, 2021 онд 11.9 нэгж хувиар тус тус буурсан байгаа бол 2022 онд өмнөх оноос 15.2 нэгж хувиар өссөн, 2023 онд 11.4 нэгж хувиар буурсан байна. Төрийн албаны тухай хууль батлагдан хэрэгжсэнээс хойшхи хугацаанд төрийн жинхэнэ албан тушаалд шаардлага хангасан иргэнийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулж томилохгүй байгаагаас төрийн жинхэнэ албан тушаалд томилох нийтлэг журам зөрчигдөж, зорилгодоо хүрч хэрэгжиж чадахгүй байна.

3.5.5. Хүний эрхийг дээдэлсэн нийгэм

“Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд хүний эрхийг хангасан хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоог бэхжүүлж, үр нөлөөг дээшлүүлэх, төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоо төлөвшүүлэх, хилийн чанадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, улс төрийн болон бусад эрхээ хэрэгжүүлэх, монгол хүүхэд эх хэлээрээ сурч боловсрох боломжийг бий болгосон эрх зүйн орчныг бүрдүүлэх, шүүх засаглалыг улс төр, бизнесийн бүлгийн ашиг сонирхлоос ангид, хараат бус байлгаж, шүүхийн үйл ажиллагаанд шударга ёсыг тогтоож, иргэдийн итгэлийг сэргээх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын хүрээнд Дэлхийн банкны засаглалын “Иргэдийн дуу хоолой ба хариуцлага” үзүүлэлтийг 2025 онд суурь түвшнээс 18.4 хувиар өсгөж, 67.6 хувьд хүргэх зорилт тавьсан бөгөөд 2023 оны үнэлгээ 56.37 хувь байгаа нь өмнөх оноос 0.05 хувиар өссөн ч суурь түвшнээс 1.3 хувиар буурсан байна.

Зураг 44. Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Иргэдийн дуу хоолой ба хариуцлага




Энэхүү үзүүлэлт нь тухайн улс орны иргэд төр засгаа сонгох үйл явцад оролцож чадаж байгаа эсэх, түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, чөлөөт хэвлэл мэдээлэл байгаа эсэхийг хэмжиж үнэлдэг.

Удирдлагын академиас 2024 онд “Засаглалын үзүүлэлт: Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлагыг хэмжих нь” сэдэвт судалгааг хийсэн ба уг судалгааны дүгнэлтээс харахад, иргэдийн улс төрийн эрхийн ойлголт нэмэгдэх тусам дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх сонирхол нэмэгдэж байгаа, иргэний нийгмийн тухай ойлголт муу, ТББ-ын үйл ажиллагаанд ямар хэлбэрээр идэвхтэй оролцох, асуудлыг эвлэлдэн нэгдэх замаар хэрхэн шийдвэрлэх, асуудлын гарцыг оновчтой тодорхойлох тал дээр ойлголтгүй, иргэд дуу хоолойгоо төрийн байгуулалд хүргэх хүсэлтэй боловч иргэдийн дуу хоолойд хариу үйлдэл үзүүлэх эгэх хариуцлагын механизм сул, иргэний эрхийн тухай мэдлэг хангалтгүй түвшинд, харин эх орондоо сайхан амьдрах боломжтой гэсэн итгэлтэй байгааг улс төрийн эрхийн хэрэгжилт муу байх нь иргэний эрхийн хэрэгжилт муудах нөхцөл болж, улмаар нийгмийн эгэх хариуцлага буурахад шууд нөлөөтэй гэж судалгаагаар дүгнэсэн байна.

Дэлхийн улс орнуудын хүний эрхийн индексийг World Justice Project байгууллагаас жил бүр тооцож гаргадаг бөгөөд энэхүү индекс нь Засгийн газрын ил тод байдал, авлигын төсөөллийн индекс, хүний эрх чөлөөний индекс зэрэг 8 үндсэн шалгуур үзүүлэлтэд үндэслэдэг. Монгол Улс 2024 онд Хүний эрх чөлөөний индексээр өмнөх оноос 4 байраар ухарч, 69 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

Зураг 45. Хүний эрх чөлөөний индекс




3.5.6. Авлигагүй засаглал

“Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, нийгмийн бүх түвшинд шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж, авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ял, шийтгэлийн бодлогыг чангатгах, төрийн бүх шатанд авлигыг таслан зогсоох хөтөлбөр хэрэгжүүлж, төр иргэдийн мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгох зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн. Энэхүү зорилтын үр дүнг

Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Авлигын хяналт, Авлигын төсөөллийн индекс зэрэг үзүүлэлтээр тооцож үнэлэв.

Дэлхийн банкны засаглалын “Авлигын хяналт” үзүүлэлтийг 2025 онд суурь түвшнээс 18.3 хувиар өсгөж, 47.2 хувьд хүргэх зорилт тавьсан ба 2023 оны үнэлгээ 35.38 хувь байгаа нь өмнөх оноос 8.7 хувиар өссөн ч суурь түвшнээс 11.3 хувиар буурсан байна.


Зураг 46. Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Авлигын хяналт



Энэхүү үзүүлэлтээр хувийн зорилгоор төрийн эрх мэдлийг ашиглаж буй байдал, жижиг болон том хэмжээний авлигын хэлбэрүүд, улс төрийн өндөр түвшинд авлига байгаа эсэх, авлига дахь элитүүдийн оролцооны түвшин, авлигын эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө зэргийг хэмжиж үнэлдэг.

“Транспэрэнси Интернэшнл” байгууллагаас жил бүр тооцож боловсруулдаг Авлигын төсөөллийн индекс нь дэлхийн улс орны төрийн байгууллагууд дахь авлигын түвшинг тодорхойлдог дэлхийн тэргүүлэх үзүүлэлт бөгөөд жил бүр 180 улс, нутаг дэвсгэрийн харьцуулсан дүр зургийг гаргадаг. Энэхүү судалгаа нь дэлхий даяар 13 судалгааны байгууллагаас мэдээлэл авч, нэгтгэгддэг бөгөөд экспертизийн үнэлгээ болон бизнес эрхлэгчдээс авсан санал асуулгаар төрийн байгууллага дахь авлигын түвшинг харуулдаг.

Зураг 47. Авлигын төсөөллийн индекс




Монгол улс 2024 онд 33 оноо авч 180 орноос 114 дүгээрт эрэмбэлэгдсэн. Эрэмбээрээ өмнөх оноос 7 байраар урагшилсан ч сүүлийн 3 жилийн оноо 33 хэвээр байсаар байна.

3.6.НОГООН ХӨГЖИЛ

Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд “Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана” гэсэн зорилгыг дэвшүүлж, эх байгаль анхдагч экосистем, байгалийн баялгийн үр өгөөж, үнэт баялаг ус, нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил гэсэн чиглэлийн хүрээнд 4 зорилт, 18 хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилго, зорилтын үр дүнг 13 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр баталсан ба эдгээрээс Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт EPI үзүүлэлтээр зорилгын хэрэгжилтийн үр дүнг үнэлэхэд, төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

Зураг 48. Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт EPI




Уг үзүүлэлтийг 2025 онд суурь түвшнээс 1.4 хувиар өсгөж, 58.0 хувьд хүргэх зорилт тавьсан бөгөөд 2024 оны үнэлгээ 37.2 хувь байгаа нь өмнөх оноос 25.7 хувиар өссөн ч суурь түвшнээс 35.0 хувиар буурсан байна.

3.6.1. Эх байгаль анхдагч экосистем

“Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистем бүхий газар нутгийг судалж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэн эдийн засгийн үр өгөөжийг үнэлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөн нийт газар нутгийн 27 хувьд хүргэж, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авах, Монгол орны ургамал газарзүйн 4-өөс доошгүй тойргийн ашиглалтад өртөмтгий 200 зүйл ургамал, 10 зүйл амьтны тархац нөөцийг тогтоож, Олон улсын улаан дансны шалгуураар 600 зүйл амьтан, ургамлыг нарийвчлан үнэлж, ховордлын шалтгааныг тодорхойлох зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын үр дүнг Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь, Улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд, төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

Зураг 49. Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь



Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2025 онд суурь түвшнээс 34.3 хувиар нэмэгдүүлж 27.0 хувьд хүргэх, улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн хэмжээг суурь түвшнээс 13.9 хувиар нэмэгдүүлж 55.0 хувьд хүргэх зорилт тавьсан ба 2025 оны эхний хагас жилийн байдлаар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь 21.0 хувь байгаа нь төлөвлөсөн үр дүнгийн 77.8 хувь, улсын тусгай хамгаалалтад авсан гол, мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь 50.0 хувь байгаа нь төлөвлөсөн үр дүнгийн 90.9 хувь байна.

3.6.2. Байгалийн баялгийн үр өгөөж

“Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохимтой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдлыг

бууруулах, ашиглалтын нөөц бий болгоно.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулах, нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээж, ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлыг зориудаар үржүүлэн тарималжуулж ашиглалтын нөөц бий болгох, байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангах, хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 8000 га талбайд нөхөн сэргээлт хийх, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.


Дээрх зорилтын үр дүнг газрын доройтлын хувь, ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлээр доройтсон газар нутгийн эзлэх хувь гэсэн шалгуур үзүүлэлтээр тооцож үнэлэхэд, газрын доройтлын хувь 2020 оны дүнгээр 22.9 хувь, ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь 8.45 хувь, эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн хэмжээ 15150 га, цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлээр доройтсон газар нутгийн эзлэх хувь 2020 дүнгээр 23.3 хувь байна. Газрын доройтлын үнэлгээ, цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлээр доройтсон газар нутгийн судалгаа 5 жил тутамд хийгддэг ба 2025 оны судалгааны үр дүн 2025, 2026 онд гарах тул газрын доройтол, цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлээр доройтсон газар нутгийн үзүүлэлтээр суурь түвшнээс ахиц өөрчлөлтийг тооцох боломжгүй байна.

Монгол орны нийт нутгийн 76 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн гэж үздэг. Түүний 56 хувь нь байгалийн үзэгдэлтэй холбоотой. Харин 44 хувь нь хүний үйл ажиллагаатай холбоотой гэсэн тоон үзүүлэлт байна. Монгол орны цөлжилтийн 2020 оны үнэлгээгээр нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая га талбай доройтсон. Үүнээс нэн хүчтэй 4.7 хувь, хүчтэй 18.6 хувийг эзлэх ба засаг захиргааны нэгжийн хувьд Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говь-сүмбэр, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Төв аймгийн нийт газар нутгийн 50-70.0 хувь цөлжилт, газрын доройтолд өртсөн гэж дүгнэсэн байна.

БОАЖЯ, Экологийн цагдаагийн алба хамтран 2020 онд улсын хэмжээнд хийсэн эвдэрсэн газрын тооллогын дүнгээр нийт улсын хэмжээнд 30,790 га эвдрэлд орсон, үүнээс нэн тэргүүнд нөхөн сэргээх шаардлагатай олон жил орхигдсон талбайн хэмжээ 8,000 га байгааг тогтоож, 2020-2024 онд уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8,000 га талбайг нөхөн сэргээх зорилтыг дэвшүүлж ажилласан.

Улсын хэмжээнд хийгддэг нөхөн сэргээлтийн хэмжээ 2020 оноос өмнө хамгийн ихдээ жилдээ 912 га талбайд хийгдэж байсан ба уул уурхайн олборлолтын улмаас эвдэрч олон жил нөхөн сэргээлт хийгээгүй биологийн олон янз байдал бүхий ойн сан, усан сан бүхий газруудад эвдрэлд оруулсан үлэмж хэмжээний талбайг яаралтай нөхөн сэргээх, улсын хэмжээнд хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаатай тэмцэх, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх хүрээнд нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж, олон талт арга хэмжээг авч ажилласны үр дүнд 2020-2024 онд нийт 12,117 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 3,032 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж, зорилтот түвшинг хангасан байна.

Зураг 50. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн хэмжээ /га/




3.6.3. Үнэт баялаг ус

“Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулах, газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулж, томоохон голууд дээр урсацын тохируулгатай, олон зориулалтаар ашиглах усан сан барих, нийт хүн амын 85-аас доошгүй хувийг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангах, нийт газар нутгийн 23 хувьд гидрогеологийн дунд масштабын зураглал хийж, усны нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлж, төлөвлөлт, менежмент хийх боломж бүрдүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын үр дүнг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь, гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдэх газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувь, хамгаалалтад авч тэмдэгжүүлсэн уст цэг, усан сан бүхий газрын тоо гэсэн шалгуур үзүүлэлтээр тооцож үнэлэхэд, 3 үзүүлэлт зорилтот үр дүндээ хүрсэн байна.

Зураг 51. Шаардлага хангасан ундны усны эх үүсвэр болон ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь



Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг 2025 онд суурь түвшнээс 3.0 хувиар өсгөж, 85.0 хувьд хүргэх зорилт тавьж, 2025 онд 84.1 хувьд хүргэсэн байгаа нь өмнөх оноос 1.1 хувиар, суурь түвшнээс 1.9 хувиар тус тус өссөн ба энэ нь зорилтот үр дүнгийн 98.9 хувь байна.

Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 2025 онд суурь түвшнээс 1.4 хувиар өсгөж, 70.0 хувьд хүргэх зорилт тавьсан ба


2025 онд 69.2 хувь байгаа нь суурь түвшнээс 0,3 хувиар өссөн нь зорилтот үр дүнгийн 98.9 хувь байна.

Гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдэх газар нутгийн нийт газар нутагт эзлэх хувийг 2025 онд суурь түвшнээс 64.3 хувиар нэмэгдүүлж, 23.0 хувьд хүргэх зорилт тавьж, 2024 оны дүнгээр 17.8 хувь байгаа нь зорилтот үр дүндээ хүрээгүй ч суурь түвшнээс 27.1 хувиар, өмнөх оноос 2.9 хувиар өссөн байна.

Гидрогеологийн 1:200000-ны масштабтай зураглалын ажлыг 2018 онд Алтайн өвөр говийн бүс нутагт 35.9 мянган км² талбайд, 2019 онд Сүхбаатар аймгийн өмнөд болон зүүн-өмнөд хэсэгт 38.7 км² талбайд, 2022 онд Сүхбаатар аймгийн баруун хойд болон Дорноговь аймгийн зүүн хойд хэсэгт 29.2 мянган км² талбайд, 2023 онд Дундговь аймгийн өмнөд хэсэг, Өмнөговь аймгийн хойд хэсэгт 11.8 мянган км² талбайд, 2024 онд Дорноговь аймгийн хойд хэсэгт 8.7 мянган км² талбайд гүйцэтгэсэн ба нийт 259500 мянган км² талбайд явуулсан байна. Гидрогеологийн дунд масштаб (1:200'000)-ын зураглал хийгдсэн талбайн хэмжээ 2024 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 17.8 хувьд хийгдсэн.

Усны эх, ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийн заагийг тогтоох арга хэмжээг жил бүр тогтмол хэрэгжүүлж байна.

Зураг 52. Хамгаалалтад авч тэмдэгжүүлсэн уст цэг, усан сан бүхий газрын тоо



3.6.4. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил

“Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан үндэсний ногоон санхүүгийн корпорац (НСК) байгуулан ногоон эдийн засгийг дэмжих төсөл, хөтөлбөрийн санхүүгийн шинэ эх үүсвэрийг бүрдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах, ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулах, Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувийг 20 хувьд хүргэх, хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээг 27 хувьд хүргэх, аймгийн төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдэж, хог дахин боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын үр дүнг хэмжих хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хувь, дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь, хот, суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь, Засгийн газрын ногоон

худалдан авалтын эзлэх хувь, нэгж ам.долларын дотоодын нийт бүтээгдэхүүнд ногдох дотоодын материалын хэрэглээ гэсэн шалгуур үзүүлэлтийг баталсан.

Хүлэмжийн хийн ялгаралт, шингээлтийн ил тод байдлын 2024 онд хийсэн анхдугаар тайлангийн үр дүнгээр хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хэмжээ 2022 оны байдлаар 7.6 хувь байна. Энэ нь 2025 онд хүрэхээр төлөвлөсөн түвшний 61.8 хувийг эзэлж байна.

Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээг 27.0 хувьд хүргэх, хот, суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын хэмжээг 52.0 хувьд хүргэх зорилтыг тавьж, гүйцэтгэлээр хот, суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь 2021-2024 онд 4.2-5.7 хувиар жил бүр өссөн ба 2024 оны дүнгээр 50.0 хувь байгаа нь зорилтот түвшний 96.1 хувь байна. Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь сүүлийн 5 жилд 11.3-17.2 хүртэл хувиар нэмэгдэж ирсэн бөгөөд 2025 оны байдлаар 26.5 хувь байгаа нь зорилтот түвшний 98.1 хувь байна.

Зураг 53.Хог хаягдлын үзүүлэлт



Нийт хаягдлын 196.3 тн буюу 23.8 хувийг дахин боловсруулж эдийн засгийн эргэлтэд оруулсан. Энгийн болон аюултай хог хаягдлыг дахин боловсруулах 65 үйлдвэрүүд рүү шилжүүлж ажиллаж байгаа бөгөөд 2020-2023 оны дунджаар нийт хог хаягдлын 73.2 хувийг ландфиллд булж, 6.1 хувийг шатааж, 7.9 хувийг дахин боловсруулсан бол 2.9 хувийг байгальд шууд хаясан байна. Дахин ашигласан, боловсруулсан хог хаягдлын бүтцийг хог хаягдлын төрлөөр авч үзвэл, 2020-2023 онд дунджаар цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал 22.2 хувь, метал бүтээгдэхүүний хаягдал 15.6 хувь, хуванцар бүтээгдэхүүний хаягдал 15.5 хувь, автомашины эд ангийн хаягдал 14.9 хувь, шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал 8.2 хувь, хүнс, био массын төрлийн хаягдал 6.2 хувь, барилгын хог хаягдал 4.7 хувь, цахилгаан барааны болон бусад хог хаягдал 12.7 хувийг тус тус эзэлж байна.


3.7.АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Амар тайван, аюулгүй нийгэм бодлогын хүрээнд “Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана” гэсэн зорилгыг дэвшүүлж, энэ хүрээнд 5 зорилт, 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Дээрх зорилгын үр дүнг Дэлхийн энх тайвны үзүүлэлт, Даяаршлын үзүүлэлтээр тооцож үнэлэхэд, дэлхийн энх тайвны үзүүлэлт 2025 оны дүнгээр 1.719, даяаршлын үзүүлэлт 2024 оны дүнгээр 63.26 оноотой байна.


Эдийн засаг, энх тайвны хүрээлэнгээс /IEP/ эрхлэн гаргадаг Дэлхийн энх тайвны индексийг гадаад мөргөлдөөн, цэргийн зардал, терроризм, хүн амины хэрэг зэрэг аюулгүй байдал, хамгаалалт зэрэг 23 үзүүлэлтээр хэмждэг бөгөөд үзүүлэлтүүдийг нэгтгэж гаргасан дундаж оноо бага байх тусам тухайн улс илүү тайван гэж дүгнэдэг.

Зураг 54. Дэлхийн энх тайвны үзүүлэлт



Монгол Улс дэлхийн энх тайвны үзүүлэлтийг 2025 онд суурь түвшнээс 10.6 хувиар бууруулж, 1.6 оноонд хүргэх зорилт тавьсан ба энэхүү төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй ч 2022 онд өмнөх оноос 0.45 хувиар, 2023 онд 0.56 хувиар, 2025 онд 6.83 хувиар буурсан нь ахицтай үзүүлэлт байна. 2025 оны дүнгээр 1.719 оноо авч, 37 дугаарт эрэмбэлэгдэж, өмнөх оноос 8 байраар ахисан байна.

Зураг 55. Даяаршлын үзүүлэлт



Швейцарын Эдийн засгийн хүрээлэнгээс жил бүр даяаршлын үзүүлэлтийг боловсруулж тооцдог бөгөөд манай улс 2025 онд энэхүү үзүүлэлтийг суурь түвшнээс 7.6 хувиар ахиулж, 61.3-д хүргэх зорилт тавьж, зорилтыг хангасан хэдий ч 2022 онд өмнөх оноос 1.63 хувиар, 2024 онд өмнөх оноос 1.37 хувиар тус тус буурсан байна.

3.7.1. Зэвсэгт хүчин

“Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлж, алба хаагчдын амьдрах нөхцөл шинэчлэгдэж, хугацаат цэргийн алба хаагч иргэдийн хувийг нэмэгдүүлэх, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэх, энхийг дэмжих ажиллагаа болон улс орны стратегийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчний оролцоо, чадавхыг нэмэгдүүлэх, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэн, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийн хангалт, бэлэн байдал дээшлүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн. Дээрх зорилтын үр дүнг батлагдсан "Оюутан цэрэг" сургалтад хамрагдах суралцагчдын тоо болон Дэлхийн цэргийн хүчний индекс (GFP) үзүүлэлтээр хэмжиж, үр дүнг тодорхойлов.


Улс орны батлан хамгаалах чадавхыг сайжруулах, дайчилгааны бэлтгэл үүрэгтний нөөцийг нэмэгдүүлэх, төрийн алба хаших, батлан хамгаалах бэлтгэлтэй иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор оюутан залуусыг их, дээд сургуульд

суралцах хугацаандаа цэргийн алба хаах боломжийг бүрдүүлж, жил бүр “Оюутан цэрэг” сургалтыг зохион байгуулж байна.

Тус сургалтад хамрагдах суралцагчдын тоог 2025 онд 5500-д хүргэх зорилт үндсэн чиглэлд тусгасан бөгөөд 2024 оны дүнгээр 5979 оюутан суралцагчдыг тус сургалтад хамруулж, зорилтот түвшинг 88.4 хувиар хангасан байна. Оюутан цэргийн сургалтаар цэргийн 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнийг бэлтгэж байгаа учир Монгол Улсын Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, цэргийн хүчний үзүүлэлтэд сайнаар нөлөөлж байна.

Дэлхийн цэргийн хүчний индексийг улс орнуудын зэвсэгт хүчний чадавхын үзүүлэлтэд үндэслэн жил бүр боловсруулж тооцдог бөгөөд индексийн бага утга нь илүү өндөр цэргийн хүчний чадавхыг илтгэдэг.

Зураг 56. Дэлхийн цэргийн хүчний индекс



Монгол Улс дэлхийн цэргийн хүчний индексээр 2021 онд 2.2000, 2022 онд 2.1800, 2023 онд 2.1847, 2024 онд 2.1500, 2025 онд 2.1135 оноо тус тус авч, сүүлийн 5 жилд 105 дугаар байрнаас урагшилж, 98 дугаарт эрэмбэлэгдсэн ахицтай байна.

3.7.2. Дархан хил

“Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг боловсронгуй болгох, хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлж, бүс нутгийн онцлогт тохирсон хил хамгаалалтын арга тактикийг шинэчлэх, улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн холбоо, зэвсэглэл, техник, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлж, албаны бэлэн байдлыг дээшлүүлэх, гадаадын иргэдийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, нэгдсэн санд бүртгэх тогтолцоог бүрдүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын үр дүнг мэдээллийн нууцлалтай, дутагдалтай байдлаас шалтгаалан шууд тоон утгаар илэрхийлэх боломжгүй байгаа бөгөөд зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна:

- Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг шалгах Монгол-Оросын хамтарсан комиссыг Монголын хэсгийн дарга, тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд болон Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагч нарын “Хил хамтран шалгах ажлыг зохион байгуулах тухай” хамтарсан тушаал гаргаж, Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын хилийг хамтран шалгах “Монгол-Оросын хамтарсан комиссын дүрэм”, Монгол Улс, Оросын Холбооны Улс хооронд улсын хилийг хамтран шалгах үед “Монгол Улс, Оросын Холбооны Улсын хилийг нэвтрэх журам”, “Монгол-Оросын улсын хилийг хилийн тэмдгээр тэмдэглэх загвар”, “Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын улсын хилийг хамтран шалгах хамтарсан ажлын хэсгийн заавар”-ыг тус тус баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.

- Хил залгаа улсын хилийн бүрэн эрхт төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй хилийн шугамын дагуу хамтарсан шалгалтыг 199 удаа зохион байгуулсан.

- Хил хамтран шалгах ажлын хүрээнд 12 бүлэг, 195 алба хаагч, 30 нэгж техниктэйгээр 404 км хэсэгт ойн огтолсон зурвас сэргээхээр төлөвлөснөөс 431 км хэсэгт ойн огтолсон зурвасыг сэргээж, ажлыг 20 хувиар давуулан биелүүлсэн.


- Монгол-Оросын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээнд тусгасан Монголын талын арчлан хамгаалах хилийн 1620 багана (тэмдэг)-ны 1228 буюу 75.8 хувийг 2023, 2024 онуудад байгалийн чулуун хилийн тэмдгээр шинэчлэн босгон, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын улсын хилийн хэсэг дэх хүрэхэд хүндрэлтэй газар оронд 403 ш хилийн тэмдгийг автомашин болон нисдэг тэргээр хүргэсэн.

- 2025 оны гуравдугаар улиралд хилийн тэмдгийг шинэчлэх ажлыг бүрэн дуусгахаар ажиллаж байна.

3.7.3. Хүн, нийгмийн амар тайван байдал

“Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэн, тогтолцоог бэхжүүлэх, Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлэх, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх гэсэн хүрэх үр дүнг төлөвлөсөн. Зорилтын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт батлагдаагүй ба төлөвлөсөн үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдуулан дараах үзүүлэлтийг үр дүнг илэрхийлэх шалгуур үзүүлэлт болгон авч үзэв.

Зураг 57.16, түүнээс насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг




Зураг 58.гэмт хэргийн улмаас хохирсон хүн (тоо), учирсан хохирол (сая.төг)



Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 2021-2023 онд өссөн үзүүлэлттэй, 2024 онд 5.0 хувиар буурсан нь шинэчлэн батлагдсан Зөрчлийн тухай хуулиар эрх хасах шийтгэлтэй гүйцэтгэх баримт бичиг шинээр нэмэгдэж, биелүүлбэл зохих гүйцэтгэх баримт бичгийн тоо өссөнтэй холбоотой юм.

Зураг 59.Шүүхийн шийдвэрийн нөхөн төлүүлэлт, сая төг



Үүнтэй холбоотойгоор зөрчлийн гүйцэтгэх баримт бичгийн биелэлтийг тооцох аргачлалыг өөрчлөн, мэдээний маягт, зааврыг шинээр боловсруулж, Үндэсний статистикийн хороо, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/24 дүгээр тушаалаар батлагдсан "Салбар статистикийн мэдээлэл боловсруулах журам"-ыг Үндэсний статистикийн хорооны даргын 2025 оны А/43, А/47 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан байна.

Хүснэгт 11. Гэмт хэргийн үзүүлэлт

№	Үр дүнгийн шалгуур	Хэмжих нэгж	2020	2021	2022	2023	2024
Зорилт 7.3. Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.							
1	Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	23064	25429	35340	35574	44673
5	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн илрүүлэлт	хувь	82.1	75	61.3	64.0	62.1
6	Хэргийг хэрэг бүртгэлт явуулж эхэлснээс хойш хуулийн хугацаанд шийдвэрлэлт	хувь	79.9	82.3	89.7	92.1	93.3
7	Эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн илрүүлэлт	хувь	78.3	76.1	77.5	84.5	85.5
8	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг	тоо	1138	1531	1729	1415	1559
9	Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил	тоо	10306	9526	10094	10319	12392
10	Камерын хяналтын нэгдсэн систем суурилуулсан суурьшлын бүс	хувь	40.0	10.0	10.0	20.0	30.0


Эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн яам

Дээрх үзүүлэлтээс харахад, гэмт хэргийн тоо 2025 онд 2020 оноос 93.7 хувиар, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн илрүүлэлт 24.4 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 37.0 хувиар тус тус нэмэгдсэн байгаа нь иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж чадахгүй байгааг харуулж байна.

3.7.4. Хууль сахиулах салбарын хөгжил

“Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчин, материаллаг баазыг бэхжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах боломж, нөхцөлийг дээшлүүлэх, шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, чадавхыг дээшлүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгох, мал хулгайлах гэмт хэргийг бууруулах, хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны зарим хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хууль сахиулах байгууллагууд иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих цахим нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдож, иргэдэд үйлчлэх таатай орчныг бүрдүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн. Зорилтын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт батлагдаагүй тул дараах үзүүлэлтээр үр дүнг илэрхийлэхийг зорив.

Зураг 60. Хууль зүйн туслалцааны төвийн үзүүлсэн өмгөөлөл, хууль зүйн үйлчилгээ



Хууль зүйн туслалцааны тухай хууль 2022 оны 07 сарын 01-ний өдөр шинэчлэн батлагдаж, иргэний, захиргааны, зөрчлийн хэргийн оролцогч, мөн зарим төрлийн гэмт хэргийн хохирогч зэрэг иргэнд үнэ төлбөр хууль туслалцаа үзүүлэхээр хуульчилснаар хууль зүйн туслалцааны төвийн үйлчлэх хүрээ нэмэгдсэн. 2025 оны 7 сарын байдлаар Хууль зүйн зөвлөгөө 6907, өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн иргэн 1878 байна.

Хууль сахиулах салбарын эрх зүйн орчин, материаллаг баазыг бэхжүүлэх хүрээнд:

- Шүүх шинжилгээний тухай хууль 2022 онд шинэчлэн батлагдаж, Засгийн газрын 2023 оны 10 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болж, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа өргөжиж, шинэ төрлийн шинжилгээ хийх эрх зүйн орчин бүрдсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох 50 журмыг батлуулж, шинжилгээгээр шийдвэрлэх асуудлын хүрээг өргөжүүлж, шинээр хүрээлэн буй орчны шинжилгээ, үнэлгээний, митохондрийн ДНХ, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын, барилга-инженерийн байгууламжийн, хэргийн газрыг сэргээн дүрслэх шинжилгээний лаборатори болон шүүх сэтгэцийн шинжилгээний тасгийг шинээр байгуулж, бүтэц, орон тоог нэмэгдүүлэн, шаардлагатай төсөв санхүүжилтийг батлуулан, үйл ажиллагааг бэхжүүлж байна. Засгийн газрын 2023 оны 182 дугаар тогтоолоор Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Ховд” аймагт бүсийн Шүүх шинжилгээний төвийг байгуулсан байна.

- Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 2.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Спорт дадлага, сургалтын байгууламж”-ийг барьж 2024 онд ашиглалтад хүлээн авсан. Баянзүрх дүүргийн 33 дугаар хороо, Гүнжийн хоолой дахь их сургуулийн дадлага, сургалтын төвийн сургалтын орчин, нөхцөлийг сайжруулан тус бүр нь 40 хүний багтаамжтай, 80 м2 талбай бүхий 11 чингэлэг сууц, шалган нэвтрүүлэх байрыг шинээр барьж тохижуулан ашиглалтад оруулсан. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий цагдаа, дотоодын цэрэг, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүх шинжилгээ, онцгой байдлын байгууллагын оператив, стратегийн түвшний удирдах бүрэлдэхүүнийг бэлтгэх сургалтын орчин нөхцөлийг бэхжүүлэх зорилгоор “Шуурхай удирдлагын төв”-ийг байгуулж, 2024 онд ашиглалтад хүлээн авсан байна.

3.7.5. Мэдээллийн аюулгүй байдал

“Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцыг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бэхжүүлэх, мэдээлэл, технологи, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн тогтолцоо бүрдүүлж, технологийн хараат байдлыг бууруулах, кибер гэмт хэрэг, кибер халдлагатай тэмцэх чадавхыг дээшлүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын үр дүнг Кибер аюулгүй байдлын индекс шалгуур үзүүлэлтээр хэмжиж үнэлэхэд, Монгол Улсын Кибер аюулгүй байдлын индекс 2020 онд 26.20 байсан бол 2024 онд 56.36 болж өсөж, “бэхжиж буй” түвшинд үнэлэгдсэн байна. Үндсэн 5 шалгуурын хүрээнд үнэлгээг авч үзвэл, хууль эрх зүйн орчин 19.18, техник 6.64, байгууллагын үйл ажиллагаа 13.62, чадавхын хөгжил 10.43, хамтын ажиллагаа 6.49 оноогоор тус тус үнэлэгдсэн. Олон Улсын Цахилгаан Холбооны байгууллагаас хоёр жил тутам тооцон гаргадаг Дэлхийн кибер аюулгүй байдлын индекс нь улс орнуудын кибер аюулгүй байдлыг хангах талаарх үйл ажиллагааг хууль эрх зүй, техник, байгууллага, чадавхын хөгжил, хамтын ажиллагаа гэсэн үндсэн таван тулгуурт шалгуурын хүрээнд хэмждэг байна.

3.8.БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд “Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагалт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ” зорилгыг дэвшүүлж, энэ хүрээнд дэд бүтэц, аялал жуулчлал, тогтвортой хөдөө аж ахуйн чиглэлийн 3 зорилт, 29 хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилгын хэрэгжилтийг орон нутгийн хөгжлийн индекс гэсэн үзүүлэлтээр үнэлэх боломжтой боловч энэ үзүүлэлтийг 2021 оноос хойш тооцоогүй байна. Засгийн газрын 2018 оны 20 дугаар тогтоолоор “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал”, “Орон нутгийн хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээлэл, тэдгээрийг гаргах байгууллагын жагсаалт”-ыг шинэчлэн баталж, Орон нутгийн хөгжлийн индексийг жил бүрийн I улиралд багтаан нийтэд зарлаж байхыг Үндэсний хөгжлийн газрын даргад даалгасан бөгөөд Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яамны харьяанд “Үндэсний хөгжлийн хүрээлэн” улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулж, чиг үүрэгт өөрчлөлт орсонтой холбоотойгоор дээрх орон нутгийн хөгжлийн индексийг тооцох ажил орхигдсон байна.

Дээрх зорилго, зорилтын хэрэгжилтийн үр дүнг хэмжих дараах 8 шалгуур үзүүлэлтийг баталсан:

- Шинээр баригдах үерийн далан суваг, ус зайлуулах шугамын урт
- Сумын төвийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжсэн сумын төвийн тоо
- Бүсийн тээвэр логиستيкийн шинээр нэмэгдэх төв
- Шинээр байгуулагдах хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркийн тоо
- Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь
- Шинээр баригдах улсын чанартай авто замын урт
- Шинээр баригдах төмөр замын урт
- Олон улсын зэрэглэлтэй болох нисэх буудлын тоо

УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталж, Монгол Улсыг Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн бүсчлэлийн тогтолцоогоор хөгжүүлэх, эхний үе шатыг 2030 он хүртэл хэрэгжүүлэхээр тусгасан байна. Бүсийн хөгжлийн зорилгын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт нь голчлон дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хийхэд чиглэсэн бөгөөд энэхүү үйл ажиллагааны үр дүнг үнэлэх бүс тус бүрээр тодорхойлсон нийт 57 шалгуур үзүүлэлт нь дээр дурдсан шалгуур үзүүлэлттэй ижил, дэд бүтцийн хүрээнд хийгдсэн ажлын гүйцэтгэлээр хэмжигдэхээр байна.


Иймд дараагийн дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусгах бодлогын зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг бүсийн хөгжлийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулж, бүсийн болон аймаг, орон нутгийн хүрээний хөгжлийн бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүнг давхардуулахгүйгээр, ялгаа, заагтайгаар тодорхойлж тусгах шаардлагатай.

3.8.1. Дэд бүтэц

“Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд Өрнө-дорнын бүсийн орнуудыг холбох дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэгийн авто зам болон хойд, урд хөршийг холбох зарим бүсийн босоо тэнхлэгийн авто замыг барих, стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр зам, авто замуудыг барих, байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, авто замын сүлжээ, үндэсний тээвэр логиستيкийн тогтолцоог хөгжүүлэх, чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийх, орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг сайжруулж, үйл ажиллагааг өргөжүүлэх, “Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төсөл, сумдад “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлэх, инновац, дэвшилтэт техник технологи, дижитал шилжилтийг зам, тээврийн салбарт нэвтрүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Монгол Улс эдийн засгийн өсөлтийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зам, тээврийн дэд бүтцийг өргөжүүлэх хүрээнд 2021-2025 онд 2022 км улсын чанартай авто зам, 1174 км төмөр замыг шинээр барихаар төлөвлөснөөс 2025 оны дүнгээр нийт 1331.2 км авто зам, 1106.2 км төмөр замыг барьж ашиглалтад оруулсан байна.

Зураг 61.Шинээр барьсан авто зам, төмөр зам (км)



Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 2024 онд 131.1 сая тонн, зорчигчид (давхардсан тоогоор) 149.4 сая болж, 2020 оноос тээсэн ачаа 69.0 сая тонн буюу 2.1 дахин өсөж, зорчигчид 22.9 сая хүн буюу 18.1 хувиар өссөн байна. Тээсэн ачаа 2023 оноос 24.6 сая тонн буюу 23.1 хувь, зорчигчид 2.4 сая хүн буюу 1.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 12.Зам, тээврийн салбарын үзүүлэлт

Нийт	2020	2021	2022	2023	2024	2025.II
Ачаа эргэлт, сая тонн/км	23,903.0	20,703.3	18,164.0	26,771.7	34,049.9	15,993.8
төмөр зам	19,209.7	18,373.8	15,540.2	19,659.2	21,274.7	10,560.6
авто зам	4,685.3	2,313.9	2,591.9	7,088.1	12,746.1	5,421.4
агаар	8.1	15.6	32.0	24.3	29.0	11.8
Зорчигч эргэлт, сая хүн/км	3,416.8	1,563.5	4,424.2	7,700.8	7,947.3	3,976.1
төмөр зам	579.3	90.7	701.5	799.3	847.4	358.3
авто зам	2,178.0	1,023.0	1,914.9	1,813.2	2,204.6	1,129.0
агаар	659.5	449.4	1,828.4	3,880.8	4,893.7	2,488.8
усан зам	0.0	0.4	0.5	1.2	1.6	
Тээсэн ачаа	62,099.3	51,691.5	63,805.5	106,437.2	131,074.9	
төмөр зам	31,641.6	33,714.7	30,717.0	36,497.7	45,899.1	
авто зам	30,455.0	17,970.3	33,075.6	69,930.9	85,165.5	
агаар	2.7	6.4	12.9	8.6	10.4	

Дээрх ачаа эргэлт, зорчигч эргэлтийн үзүүлэлтийг шинээр баригдсан авто зам, төмөр замын үзүүлэлттэй харьцуулан үзэхэд, 2022 онд 292.01 км авто зам ашиглалтад ороход авто замаар зорчих зорчигч эргэлт 87.2 хувиар нэмэгдэж, авто замаар тээвэрлэх ачаа эргэлт 12.0 хувиар нэмэгдсэн байна. 2023-2024 онд нийт 1106,2 км төмөр зам барьж ашиглалтад оруулахад төмөр замаар тээвэрлэх ачаа эргэлт 2023 онд өмнөх оноос 26.5 хувиар, 2024 онд 8.2 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Авто замын сүлжээ, үндэсний тээвэр логикийн тогтолцоог хөгжүүлэх хүрээнд нийт 4 бүсийн тээвэр логикийн төв шинээр барьж байгуулахаар төлөвлөсөн ба дараах 6 төвийг улсын төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтаар байгуулсан байна:

1) Гашуунсухайт боомтод жилдээ 10,0 сая тн чингэлэгтэй нүүрс шилжүүлэн ачих хүчин чадалтай терминал байгуулж, 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр ашиглалтад оруулсан.

2) Шивээхүрэн боомтод 17 га талбайд 30 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар жилдээ 10 сая.тн нүүрс экспортлох чингэлэг тээврийн терминал байгуулан 2022 онд ашиглалтад оруулсан.

3) Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн цэргийн 0119 анги Замын-Үүд-Эрээн боомтын дундын бүсэд чингэлэг шилжүүлэн ачих талбайн өргөтгөлийн бүтээн байгуулалтын ажлыг хийж дуусгасан.

4) “Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв”-ийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Бодь интернэйшнл” ХХК ажиллаж, 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр ашиглалтад оруулсан.

5) “Ландбридж” ХХК нь Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд 13000м² талбай бүхий бүрэн автомат логистикийн төвийг “Urban Tower” нэртэйгээр байгуулж, 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр ашиглалтад оруулсан.

6) “Драгон холдинг” ХХК 30000м² талбай бүхий байгууламж, нэг ээлжинд 20 гаруй автобус, өдөрт 260 автобус зорчигч тээврийн үйлчилгээнд гарах боломжтой 3000 м.кв тусгай зогсоол бүхий “Улаанбаатар хотын баруун терминал”-ыг барьж, 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр нээлтээ хийсэн байна.

3.8.2. Аялал жуулчлал


“Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэг саяд хүргэх, “Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор” байгуулж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр холбох ажлуудыг үе шаттай зохион байгуулж, түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг Хөвсгөл, Хэнтий, Архангай, Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан зэрэг аймагт хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлогыг нэмэгдүүлэх зэрэг хүрэх үр дүн, үйл ажиллагааг төлөвсөн.

Дээрх зорилтын үр дүнг Дэлхийн эдийн засгийн байгууллагаас гаргадаг “Аялал, жуулчлалын хөгжлийн индекс” үзүүлэлтээр үнэлэхэд, Монгол Улс 2019 онд 3.5 оноогоор 93 дугаарт эрэмбэлэгдэж байсан бол 2021 онд 3.6 оноо 84 дүгээрт, 2024 онд 3.57 оноо авч, 85 дугаар эрэмбэлэгдэж, 2024 онд 2019 оноос оноо 2.0 хувиар өсөж, 8 байраар урагшилсан бол өмнөх оноос 0.83 хувиар оноо буурч, 1 байраар ухарсан байна.

Аялал жуулчлалын хөгжлийн индекс (TTDI) нь аялал жуулчлалын салбарын тогтвортой байдал, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, үйлчилгээ, нөөц, бодлогын багцыг хэмждэг бөгөөд 2007 оноос хойш хоёр жилд нэг удаа хэвлэгддэг Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индексийн (TTCI) шинэчлэгдсэн үнэлгээ юм.

Аялал жуулчлалын салбарын үр дүнг илэрхийлэх өөр нэг шалгуур үзүүлэлт бол хүлээн авах гадаадын жуулчдын тоо бөгөөд 2025 онд хүлээн авах жуулчдын тоог 1 саяд хүргэхээр зорьж, Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарлаж, “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, “Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах үйл ажиллагааг идэвхжүүлэх нэгдсэн стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж ажилласны үр дүнд гадаадын жуулчдын тоо нэмэгдэж, аялал жуулчлалын салбарын орлогыг нэмэгдүүлж, улсын эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулж байна.

Зураг 62. Хүлээн авах гадаад жуулчдын тоо (сая. хүн)



Хүлээн авах жуулчдын тоо 2024 онд 727.4 мянгад хүрсэн нь 2020 оноос 12.4 дахин, 2021 оноос 22 дахин, 2022 оноос 2.5 дахин, 2023 оноос 22.5 хувиар тус тус өссөн байна.


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 1212.mn

3.8.1. Тогтвортой хөдөө аж ахуй

“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах, махны экспортын хэмжээг нэмэгдүүлэх, малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, малын чанар, ашиг шимийг сайжруулах, тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тээвэр, борлуулалтын ложистикийн сүлжээг байгуулах, жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд зориулан санхүүжилтийн шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тэжээл, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, малчдын орлогыг өсгөх, малын гаралтай түүхий эдийн үйлдвэрлэгчдийг дэмжих, экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрүүдийг барих, хяналтын гурван талт түншлэлийн механизмыг бий болгох зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.


Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр “органик, баяжуулсан, зохицуулах үйлчилгээтэй инновац нэвтрүүлсэн шинэ бүтээгдэхүүн”, “хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны нийт махны хэрэглээнд эзлэх хувь”, “хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүний нийт сүүний хэрэглээнд эзлэх хувь” 3 шалгуур үзүүлэлт тусгагдсан бөгөөд эдгээрээс 1 шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн бол 2 шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн түвшинг илэрхийлэх дараах үзүүлэлтүүд байна.

Зураг 63. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл (сая.төг)



Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2024 онд 9.33 их наяд төгрөг болж, 2020 оноос 22.4 хувиар өссөн бол өмнөх оноос 12.8 хувиар буурсан нь мал аж ахуйн үйлдвэрлэл буурсантай холбоотой байна. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2024 онд өмнөх оноос 32.7 хувиар буурсан бол газар тариалангийн бүтээгдэхүүн 11.8 хувиар өссөн байна.


Зураг 64. Хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, сүүний нийт хэрэглээнд эзлэх хувь



Хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны нийт махны хэрэглээнд эзлэх хувийг 2025 онд суурь түвшнээс 57.7 хувиар нэмэгдүүлж, 50.0 хувьд хүргэхээр, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүний нийт сүүний хэрэглээнд эзлэх хувийг суурь түвшнээс 101.3 хувиар нэмэгдүүлж, 30.0 хувьд хүргэхээр төлөвлөсөн ч зорилтот түвшиндээ хүрээгүй байна. 2024 оны дүнгээр боловсруулсан сүүний нийт сүүний хэрэглээнд эзлэх хувь 15.5 хувь болж, суурь түвшнээс 4.0 хувиар өссөн ч өмнөх оноос 24.4 хувиар буурсан байгаа бол үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны нийт махны хэрэглээнд эзлэх хувь 2024 онд 27.0 хувь болж, суурь түвшнээс 14.8 хувиар, өмнөх оноос 41.3 хувиар тус тус буурсан байна.

Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчинтэй тэмцэх зорилгоор 2020-2024 онд халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, гоц халдварт өвчний вакцинжуулалтад нийт 171.85 тэрбум төгрөг зарцуулж, үүний үр дүнд мал, амьтны халдварт өвчний гаралт буурч, халдварт өвчин гарсан сумын тоо 2020 оноос 82.7 хувиар, өвчилсөн малын тоо 73.0 хувиар тус тус буурсан байна. Ингэснээр мах, түүхий эд бүтээгдэхүүнийг эрүүл, тайван бүсээс бэлтгэж, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Зураг 65.Малын эрүүл мэндтэй холбоотой үзүүлэлт




3.9.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

Улаанбаатар ба дагуул хот бодлогын хүрээнд “Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлж, хүн төвтэй хот, орчин төвтэй шийдэл, төлөвлөлт төвтэй хөгжил, хотын сайн засаглал, дагуул хот гэсэн чиглэлийн хүрээнд 5 зорилт, 21 хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилгын үр дүнг илэрхийлэх гол шалгуур үзүүлэлт бол Хотын хөгжлийн индекс бөгөөд 2025 онд энэ үзүүлэлтийг суурь түвшнээс 13.5 хувиар ахиулж, 0.572-т хүргэх зорилт тавьсан. 2021-2023 онд энэ үзүүлэлт 1.01-19.2 хүртэл хувиар буурсан буюу 2022-2024 онд суурь түвшнээс бага үнэлгээтэй байна.

Зураг 66. Хотын хөгжлийн үзүүлэлт



Эх сурвалж: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн статистикийн газар, 2024


Хотын хөгжлийн индексийг тооцох аргачлал 2023 оноос өөрчлөгдөж, өмнө нь 6 бүлэг 30 шалгуураар үнэлж байсан бол одоо тогтвортой байдал, амьдрах орчны чанар, хүртээмжтэй байдал, өрсөлдөх чадвар гэсэн 4 бүлэг, боловсрол, эрүүл мэнд, нийгэм, засаглал, дэд бүтэц, эдийн засаг гэсэн 6 төрлийн 86 шалгуураар үнэлдэг болсон байна. Улаанбаатар хотын 2024 оны хөгжлийн индексийг нийслэлийн Бодлогын судалгаа, шинжилгээний төв, Шинжлэх Ухааны Академи, их дээд сургуулиудын харьяа эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүдтэй хамтран тооцсон байна. 2023 оны 12 дугаар сарын тооцооллоор Улаанбаатар хотын хөгжлийн индекс (ХХИ) = 0.433 (F түвшин) гарсан нь олон улсын жишигтэй харьцуулахад доогуур үзүүлэлтэд тооцогдож байна.

3.9.1. Хүн төвтэй хот

“Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай, бүсчилсэн сүлжээг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангах, хотын соёлт иргэнийг төлөвшүүлэхэд бүх шатны боловсролын байгууллагуудыг хамарсан төсөл хэрэгжүүлж, нийгэмд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг төрийн байгууллага, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж хэвшүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын хүрээнд нийслэлийн хэмжээнд улс, нийслэл, дүүрэг, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр нийгмийн үйлчилгээний байгууллагуудын хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, 2020-2024 онд 27618 суудлын хүчин чадалтай 45 сургуулийн барилга, 18705 орны хүчин чадалтай 114 цэцэрлэгийн барилга, 1160 суудлын болон 1080 орны хүчин чадалтай 8 бага сургууль цэцэрлэгийн барилгыг тус тус барьж ашиглалтад оруулсан байна.

Зураг 67. Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургууль цэцэрлэг, хамрагдсан хүүхэд




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2024

Нийслэлийн боловсрол, эрүүл мэндийн салбарт 2025 оны байдлаар гадаадын зээл тусламжийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд нийслэлийн түргэн тусламжийн төвийн барилга, 9 өрхийн эрүүл мэндийн төв, Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт 2 жишиг нэгдсэн эмнэлгийн барилга, нийт 12 төсөл хэрэгжсэн бөгөөд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 28.1 тэрбум төгрөгийн тоног, төхөөрөмж, 11.9 тэрбум төгрөгийн засвар үйлчилгээний ажил хэрэгжиж байна.

Эрүүл мэндийн салбарт 2020-2024 онд 13 эмнэлгийн барилга, 11 бие даасан өрхийн эрүүл мэндийн төвийн барилга, 12 өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга, нийт 36 эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвийн барилга шинээр ашиглалтад орж, нийслэлийн хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.

Зураг 68. Улаанбаатар хотын өрхийн эрүүл мэндийн төв, эмч, сувилагчийн тоо



Өрхийн эрүүл мэндийн төв 2023-2024 онд 15.3 хувиар нэмэгдсэн бол тэнд ажиллах эмчийн тоо жил бүр 1.2-7.7 хувиар, сувилагчийн тоо 0.8-8.5 хувиар нэмэгдсэн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2024, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар


3.9.2. Орчин төвтэй шийдэл

“Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг хангаж, нөхөн сэргээх, харицлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь бууруулах, хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болох, ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгох, олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Хотын хөгжлийн индексийн 2023 оны 12 дугаар сарын тооцооллоор амьдрах орчны чанарын үзүүлэлт 0.490 байгаа бөгөөд хотын орчны үзүүлэлтэд хамаарах ногоон байгууламжийн чанар үзүүлэлт 0.207, хог хаягдлын менежмент 0.483, стрессийн түвшин 0.471 үнэлгээтэй байна.

Дээрх зорилтын үр дүнг илэрхийлэх “Улаанбаатар хотын агаар дахь PM 2.5 тоосонцрын 2024 оны жилийн дундаж агууламж”, “Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж” шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

Зураг 69. Улаанбаатар хотын агаарын чанарын үзүүлэлт



Эх сурвалж: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

Хог хаягдлыг дахин боловсруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийх хүрээнд өнгөрсөн хугацаанд 8.5 сая тонн хог хүлээн авах хүчин чадалтай эрүүл ахуйн шаардлага хангасан ландфил, өдөрт 100 тонн барилга нураалтын хог дахин боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор барилгын салбарын хаягдлыг үр ашигтай шийдвэрлэх боломж бүрдсэн.

Нийслэлд 39 үйлдвэр үйл ажиллагаа явуулж, 2024 онд нийт хог хаягдлын 9.0 хувийг дахин боловсруулж эдийн засгийн эргэлтэд оруулсан. Хаягдал картон, хуванцар, төмөр, хөнгөн цагаан зэрэг дахин ашиглагдах материал эдийн засгийн эргэлтэд орсноор түүхий эдийн импортын хамаарлыг бууруулах, ажлын байр нэмэгдэх нөхцөл бүрдэж байгаагийн зэрэгцээ эрчим хүчний хэмнэлт, байгаль орчны нөхөн сэргээлт, эдийн засгийн эргэлтийн өсөлт гэсэн олон талын эерэг үр дүн гаргаж байна.

Нийслэлийн барилга байгууламжийн хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулах, нөөц баялгийг илүү үр ашигтай зарцуулах боломжийг нэмэгдүүлэхэд ногоон барилга, ногоон байгууламж чухал ач холбогдолтой бөгөөд ногоон байгууламжийн тоо хэмжээг илэрхийлсэн тодорхой үзүүлэлт байхгүй байна.

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгох зорилтын хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/07 дугаар тогтоолоор UCS1101C:2025 "Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл" хотын стандартыг баталсан бөгөөд энэхүү стандарт нь хотын барилгажилтын суурь норм болж, шинэ хороолол, амины орон сууцны бүсийг нэгдсэн шаардлагаар төлөвлөх нөхцөлийг бүрдүүлж байна.


3.9.3. Төлөвлөлт төвтэй хөгжил

“Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв баригдаж төвлөрлийг бууруулах, хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлэх, олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийг хэрэглээнд нэвтрүүлэх, зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудалтай болох, Богд уулыг тойрсон “Хөгжлийн алтан тойрог” байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Дээрх зорилтын үр дүнг авто замын сүлжээний урт, тээврийн хэрэгслийн дундаж хурд, шинээр баригдах дугуйн замын урт, явган хүний зам, талбай, байгаль орчинд


ээлтэй автобус гэсэн шалгуур үзүүлэлтээр авч үзвэл, авто замын сүлжээний урт 1261.1 км-ээр, явган хүний зам, талбай 214.3 мянган м2-аар, дугуйн зам 114.47 км-ээр тус тус нэмэгдсэн байна

Зураг 70. Шинээр барьсан явган хүний болон дугуйн зам




Сүүлийн 3 жилийн хугацаанд хот доторх тээврийн хэрэгслийн дундаж хурд 8-12 км/цаг хооронд хэлбэлзэж байна. Замын хөдөлгөөний оргил ачааллын үед 2021 онд дундаж хурд 11 км/цаг байсан бол 2024 онд 22 км/цаг болсон байна.

Зураг 71. Тээврийн хэрэгслийн хурд (км/цаг)



Хот дахин хөгжүүлэх, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2014-2025 онд нийт 20,825 айлын орон сууц ашиглалтанд орсон, үүнээс 2021-2025 онд 10,530 айлын орон сууц ашиглалтанд оруулсан байна.

Зураг 72. Ашиглалтад орсон орон сууц (айл)



2025 онд 4245 өрхийн орон сууц ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Хотын хөгжлийн индексийг тодорхойлох 2023 оны 12 дугаар сарын тооцоолол судалгаагаар орон сууцны хүртээмж 0.505, нийтийн тээврийн хүртээмж 0.429, ногоон байгууламжийн хүртээмж 0.125, явган зам, дугуйн замын хүртээмж 0.295 оноогоор үнэлэгдсэн байна.

Эх сурвалж: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар


3.9.4. Хотын сайн засаглал

“Хууль, эрх зүйн шинэчлэл хийж, хотын засаглал, эдийн засаг, нийгмийн таатай орчныг бүрдүүлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд хотын засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэн бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл олж авах сувгийг нээлттэй, хүртээмжтэй, ил тод болгох, нийслэл эдийн засгийн хувьд бие даан хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлэх, Дархан, Эрдэнэт болон бусад том хотуудыг улсын зэрэглэлтэй болгож, хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн.

Нийслэл эдийн засгийн хувьд бие даан хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах 36 хуулийн төслийг боловсруулсан ба Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн чуулганаар хэлэлцэж баталсан. Нийслэл Улаанбаатар хотыг 14 хот, 42 хороогоор шинээр зохион байгуулснаар төвлөрлийг сааруулж, “20 минутын хот” стандарт хэрэгжих нөхцөл бүрдэхийн зэрэгцээ иргэд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, худалдаа үйлчилгээ зэрэг суурь үйлчилгээг амьдран суугаа газраасаа 20 минутын дотор авах боломжтой болно. Түүнчлэн нийслэлийн үйлчилгээ төвийн дүүрэгт төвлөрөх биш дэд төвүүдэд жигд тархах боломж бүрдэж, нийслэлийн авто замын ачаалал, түгжрэл буурах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.


Дээрх зорилтын үр дүнг хүний хөгжлийн индекс /Улаанбаатар/, дотоодын нийт бүтээгдэхүүн, нэг өрхийн сарын дундаж орлого, Авлигын индекс үзүүлэлтээр авч үзэхэд, нийслэлийн хүн амын боловсролын түвшний индекс 2024 онд 0.80 байгаа нь 2022 оны түвшнээс 10.1 хувиар буурсан бол дундаж наслалт 1.25 хувиар, нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын индекс 3.9 хувиар тус тус өссөн байна.

Зураг 73. Хүний хөгжлийн индекс (Улаанбаатар)




Улаанбаатар хотын нэг өрхийн сарын дундаж орлого 2021 онд өмнөх оноос 1.9 хувиар өссөн бол 2022 онд 17.0 хувиар, 2023 онд 18.0 хувиар, 2024 онд 23.1 хувиар тус тус өссөн байна.

Зураг 74. Нэг өрхийн сарын дундаж орлого (Улаанбаатар)



Авлигатай тэмцэх газраас жил бүр холбогдох байгууллагатай хамтран хийдэг Шударга байдлын үнэлгээний хүрээнд Авлигын индекс үзүүлэлтийг тооцдог бөгөөд энэ үзүүлэлт нь авлигын талаарх төсөөлөл, авлигын шууд болон шууд бус тохиолдол гэсэн 3 дэд үзүүлэлттэй байна.

Зураг 75. Авлигын индекс



Тус байгууллагын хийсэн үнэлгээгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын авлигын индекс 2024 онд 78.9 оноогоор үнэлэгдсэн нь 2020 оны түвшнээс 29.9 хувиар өссөн ч өмнөх оны үнэлгээнээс 6.4 хувиар буурсан байна. Авлигын индексийн дэд үзүүлэлтийн хувьд авч үзэхэд, авлигын талаарх төсөөлөл өмнөх оноос 4.3 оноогоор дээшилсэн бол авлигын шууд тохиолдол 3.0 оноогоор, Авлигын шууд бус тохиолдол 1.2 оноогоор буурч үнэлэгдсэн байна.

3.9.5. Дагуул хот


“Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ.” зорилтыг дэвшүүлж, энэ хүрээнд олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлж, “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эхлүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлэх, зүүн хойд Азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төв болгох ажлыг эрчимжүүлж, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулах, Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх, дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлэх, хот, тосгоныг холбосон хурдны тойрог зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулж, монгол брэндийн худалдааны төвийг нээн ажиллуулах, цахим эдийн засаг, үйлчилгээний салбарыг дэмжихэд шаардлагатай дэд бүтэц болох Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулах зэрэг хүрэх үр дүнг төлөвлөсөн. Зорилтын үр дүнг өрсөлдөх чадварын үзүүлэлт, дотоодын нийт бүтээгдэхүүн /Улаанбаатар/, дотоодын нийт бүтээгдэхүүнд хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэрэг үзүүлэлтээр авч үзэв.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв нь нийслэл, дүүргүүдийн өрсөлдөх чадварыг 2017 оноос судалж эхэлсэн ба дүүргүүдийн өрсөлдөх чадварыг хэмжих, мэдээллийн сан үүсгэх, өрсөлдөх чадварын өөрчлөлт, чиг хандлагыг судлах зорилготой энэхүү судалгааг хоёр жил тутамд боловсруулдаг. Судалгааг үндсэн 5 бүлэг, 15 дэд бүлэг, нарийвчллан тодорхойлсон 150 шалгуур үзүүлэлтээр хэмждэг.

Улаанбаатар хотын дүүргүүдийн өрсөлдөх чадварын 2021 оны үнэлгээгээр Улаанбаатар хотын өрсөлдөх чадварын ерөнхий индекс 0.545 оноогоор үнэлэгдсэн бол 2023 онд 0.568 оноогоор үнэлэгдэж, индекс 4.2 хувиар ахисан байна.

Нийслэлийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2021-2024 онд өмнөх оноосоо 13.46-38.48 хувиар өссөн байна.

Зураг 76.Дотоодын нийт бүтээгдэхүүн, тэрбум төг (Улаанбаатар)



Харин дотоодын нийт бүтээгдэхүүнд хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувь 2021 онд өмнөх оноос 1.3 хувиар өссөн ч 2022-2023 онд өмнөх оноосоо 1.6-3.8 хувиар буурсан байна.

Хотын хөгжлийн индексийг тодорхойлох 2023 оны 12 дугаар сарын тооцоолол судалгаагаар өрсөлдөх чадварын бүлэгт хамаарах хөрөнгө оруулалтын үзүүлэлтийн эдийн засгийн төрөлжилт хэсэг дэх үйлдвэрлэл 0.250, хөдөө аж ахуй, 0.300, хөрөнгө оруулалтын төрөл 0.260 оноогоор үнэлэгдсэн нь хангалтгүй үзүүлэлт байна. Мөн эрүүл мэндийн хөрөнгө оруулалт 0.115, боловсролын хөрөнгө оруулалт 0.194, төсвийн хөрөнгө оруулалт 0.297 үнэлгээтэй байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Амар тайван аюулгүй нийгэм, Бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлж, 243 хүрэх үр дүнг 95 хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлттэйгээр баталсан.

Өмнөх жилүүдэд энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэхдээ арга хэмжээний хэрэгжилтийн хувиар үнэлдэг байсан бол энэ удаагийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн “Хяналт шинжилгээ хийх журам”-д заасан аргачлалыг баримтлан батлагдсан 95 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжилтийн үр дүнг тодорхойлж, мөн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, үр дүнг илэрхийлэх нэмэлт 96 үзүүлэлтийн мэдээллийг ашиглав.

Шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшний үзүүлэлтийг 2025 оны хүрэх түвшинтэй харьцуулан үнэлэхэд хүндрэлтэй байгаа ба энэ нь тайлант хугацаа бүрэн дуусаагүй, зарим үзүүлэлтийн 2024, 2025 оны үзүүлэлт гараагүй буюу Үндэсний статистикийн хорооны статистик мэдээлэл гарах хугацаа болоогүй, олон улсын байгууллагын үнэлгээний үр дүн гараагүй зэрэг асуудалтай холбоотой байна.

Хэрэгжилтийн үнэлгээний дүнгээс үзэхэд, 95 шалгуур үзүүлэлтээс 34 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 85.0 дээш хувь буюу “үр дүн гарсан”, 53 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин 85.0-аас бага хувь буюу “үр дүнгүй” гэж үнэлэгдсэн. 8 шалгуур үзүүлэлт судалгааны дүн гарах хугацаа болоогүй, тухайн чиглэлээр тодорхой судалгаа хийгдээгүй, мэдээллийн эх сурвалж, аргачлал тодорхойгүй зэрэг шалтгааны улмаас үнэлэгдээгүй байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт бүрэн хангагдаагүй нь тус төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа нөхцөл байдлын болон зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн урьдчилсан судалгааг бодитой, бүрэн хийж, хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хүрээг зөв тодорхойлоогүй, хүрэх үр дүнгийн жил бүрийн зорилтот түвшинг ытооцож төлөвлөөгүй, мөн баримт бичгийн төслийг дээд шатны байгууллагад өргөн барихаас өмнө бодлого хэрэгжүүлэгч байгууллагуудад танилцуулж эцэслэн тохироогүйгээс төлөвлөгөөнд хэрэгжих боломжгүй арга хэмжээ нэмж тусгагдсан зэргээс шалтгаалж байгаагийн зэрэгцээ хэрэгжүүлэгч байгууллагаас 5 жилийн үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт

хийж, зорилтын үр дүнг нэгтгэн бүрэн, тодорхой тайлагнаагүй, статистик болон бусад мэдээллийн дутагдалтай байдал зэргээс шалтгаалж байна.

Үндсэн чиглэлд "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогын баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 25.2 хувийг хэрэгжүүлэхээр тусгасан, Улсын хөгжлийн 2022-2025 оны төлөвлөгөөнд үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээний 25.5-43.6 хувийг төлөвлөсөн нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх" шаардлагыг хангаагүй, урт, дунд, богино хугацааны бодлогын төлөвлөлт уялдаагүй, хэрэгжилт хангалтгүй үнэлэгдэх шалтгаан болж байна. Цаашид Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсвийн уялдаа, хамаарлыг бодитой тооцон оновчтой төлөвлөж, санхүүжилтийн гүйцэтгэлийг бодлогын баримт бичиг тус бүрээр бодитой тооцож, зорилго, зорилт, үйл ажиллагааны үр дүнг зарцуулсан төсөв, хөрөнгө оруулалттай нэгтгэн дүгнэж үнэлэх шаардлагатай байна.

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төлөвлөлттэй холбоотой асуудал:

- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилт нь тунхгийн шинжтэй;
- Зорилго, зорилтын хүрээнд хамаарах хүрэх үр дүнг агуулгын хувьд давхардуулж оруулсан;
- Зорилтын хүрээнд хүрэх үр дүнг үйл ажиллагаа, арга хэмжээ, зорилт хэлбэрээр томъёолсон;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг зорилго, зорилт тус бүрээр тодорхойлоогүй;
- Шалгуур үзүүлэлт нь төлөвлөсөн үр дүнгийн хэрэгжилтийг хэмжих боломжгүй.

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэхэд тулгарч байгаа асуудал:

- Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ хийхдээ 2025 оны хүрэх түвшинд үндэслэн механик тооцооллоор тухайн оны түвшинг тооцож байсан нь зарим зорилт, үр дүнгийн хувьд оновчтой бус байсан бөгөөд 2025 оны хүрэх түвшнээр үнэлэх боломжгүй байсан.
- Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх цаглавар хугацаа нь шалгуур үзүүлэлтийн мэдээлэл гарах давтамжтай нийцэхгүй, бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэлэхэд шаардлагатай албан ёсны статистикийн мэдээлэл тухай бүр гаргахгүй байгаагаас тайлант хугацааны мэдээлэл бүрэн гарахгүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ албан ёсны мэдээлэлд үндэслэн бодитой хийгдэж чадахгүй байна.
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дах заалт бүрэн хэрэгжихгүй буюу Үндэсний статистикийн хороо ЭЗХЯ, салбарын яамд болон бусад төрийн захиргааны байгууллагад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай шалгуур үзүүлэлт, түүний эх үүсвэр, тооцох аргачлалыг тодорхойлох, бий болгоход хамтран ажиллах, статистикийн мэдээллийн баазыг өргөтгөх чиглэлээр хангалттай ажиллахгүй байна.
- Үндэсний статистикийн хорооны статистик мэдээлэл, салбарын яам, байгууллагаас гаргасан мэдээлэлтэй зөрүүтэй байна. Тухайлбал, аялал жуулчлалын салбарын үзүүлэлт.
- Салбарын үр дүнг харуулах статистик болон бусад мэдээлэл яамдаас бүрэн гарахгүй байна.

- Төрийн байгууллага хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа үр дүнг бус, үйл ажиллагааг тайлагнаж, хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тайлагнахгүй, нотлох баримтыг хавсаргахгүй байна.

- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үр дүн, үр нөлөөг тодорхойлох судалгааг тодорхой давтамжтайгаар тогтмол хийгдэхгүй байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн үнэлгээний дүнд үндэслэн цаашид дараах асуудалд анхаарч ажиллахыг Зөвлөмж болгож байна. Үүнд:

Эрх зүйн орчинг сайжруулах хүрээнд:

1. Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлагыг бэхжүүлэх хүрээнд урт, дунд, богино хугацааны бодлогын төлөвлөлт, төсөвлөлт, мониторинг, үнэлгээ хийх эрх зүйн орчныг бүрдүүлж, нэгдсэн удирдлагын системийг хөгжүүлэх;

2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх” гэж заалтыг хэрэгжүүлэх явцад төлөвлөгөөний давхардал үүсэх магадлалтай тул уг заалтыг хэрхэн хэрэгжүүлэх арга замыг тодорхой болгож, шаардлагатай тохиолдолд хуульд өөрчлөлт оруулах;

3. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж дууссаны дараа хийх үнэлгээний арга зүйг тодорхойлж, аргачлалыг боловсруулж батлах;

4. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцын үнэлгээг дунд, богино хугацааны бодлогын хэрэгжилт, үр дүнтэй уялдуулан хийж байх, төлөвлөлтийг давхардуулахгүй байх талаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;

5. Хөгжлийн бодлогын дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах аргачлал, бодлогын өртөг тооцох аргачлалыг баталж мөрдүүлэх;

6. Хөгжлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт, тодотгол хийдэг байх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

7. УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталж, бүсийн зорилго, зорилтуудыг дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосны дагуу бодлогын баримт бичиг, үзэл баримтлалд тусгагдсан ижил агуулга бүхий зорилго, зорилт, арга хэмжээний ялгаа, заагийг тодорхой болгох, эсхүл цаашид хөгжлийн бодлогыг бүсийн хөгжлөөр төлөвлөж хэрэгжүүлэх, аймаг, орон нутгийн болон бүсийн хөгжлийн үр дүнг үнэлэх асуудлыг тодорхой болгох.

Бүтээмж, үр дүнг сайжруулах хүрээнд:

1. Байгууллагын дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний үүрэг ролийг нэмэгдүүлж, удирдах албан тушаалтан бодлого, үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт, шийдвэр гаргалтыг хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн хийдэг байх чиглэлээр удирдлагын манлайллыг бий болгож төлөвшүүлэх;

2. Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистикийн нэгжийг математик, статистик мэргэжлийн хүний нөөцөөр бүрдүүлэхэд анхаарч, аливаа бодлогын хэрэгжилт, үр дүнг судалж, үнэлэлт дүгнэлт өгдөг, статистик судалгаа, мэдээлэл, өгөгдлийг боловсруулж ажилладаг чадамжтай болгох;

3. Бодлого хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, салбар, мэргэжлийн болон байгууллагын амбиц, ашиг сонирхлоос илүүтэйгээр нийтийн эрх ашигт чиглэсэн бодлого, үйл ажиллагааг үр дүнд хүргэж хамтран хэрэгжүүлэх;

4. Бодлого, арга хэмжээний үндсэн хэрэгжүүлэгч байгууллага нь тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хамтрагч байгууллагуудыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үр дүнтэй хамтран ажиллах, эргэх уялдаа холбоог сайжруулах, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших;

Үр дүнг үнэлэх, тайлагнах, мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах хүрээнд:

1. Бодлогын үр дүнгийн шалгуурын дагуу тоон үзүүлэлтийг жил бүр тогтмол гаргаж, салбарын статистик үзүүлэлтийг боловсронгуй болгох талаар төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах, шаардлагатай асуудлаар 2 жил тутам түүвэр судалгаа хийж байхыг Үндэсний статистикийн хороонд үүрэг болгох;

2. Засгийн газраас тухайн жилд бодлогын үр дүнг судлах асуудлын жагсаалтыг гаргаж, энэ дагуу салбарын яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар жилд 2-оос доошгүй бодлогын үр дүнг судлах ажлыг боломжит нөөцөд тулгуурлан хийж хэвших, байгууллагын мэдээлэл, статистикийн хэлтэст судалгааны арга зүй, статистикийн чиглэлээр мэргэшсэн албан хаагчдыг ажиллуулж, судалгааны ажлыг удирдан явуулдаг чадварыг хөгжүүлэх;

3. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үндэслэн тооцож, тухайн бодлогын үр дагавар, үр нөлөөг тодорхойлох байдлаар үнэлгээг хэрэгжүүлэх;

4. Бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилтийн хүрсэн үр дүнг бүрэн, тодорхой тайлагнаж, нотлох баримтад тулгуурласан хяналт-шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх;

5. Сангийн яамнаас хөгжлийн бодлогын баримт бичгийн арга хэмжээ бүрээр төлөвлөсөн төсөв, санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээллийг улирал тутамд нэгтгэн бодлого хэрэгжүүлэгч байгууллагуудад хүргүүлдэг байх, бодлогын үр дүнг санхүүжилтийн мэдээлэлтэй уялдуулж нэгтгэн дүгнэдэг байх;

6. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнгийн тайлан, мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг хангаж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний үр дүнг нэгтгэн тайлагнаж байх.

Хөгжлийн бодлогын дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах хүрээнд:

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг дунд, богино хугацааны бодлогын төлөвлөлтийн үе шатанд тодорхой авч үзэж бодлогын уялдааг хангаж төлөвлөж хэрэгжүүлэх;

2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа урт, дунд, богино хугацааны ялгаа заагийг харгалзан бодлогын үр дүнгийн хүрэх түвшинг суурь судалгаа, бодит нөхцөл байдалд тулгуурлан үе шаттайгаар оновчтой тодорхойлж төлөвлөх;

3. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулахдаа таван жилийн дараа хүрэх үр дүнг зорилго, зорилт хэлбэрээр тодорхойлж, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинг он тус бүрээр тогтоох;

4. Үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй холбоотой албан ёсны статистик мэдээлэл болон бусад салбарын статистик мэдээллийг тогтмол хугацааны давтамжтайгаар гаргадаг болох, мэдээллийн эх сурвалж, мэдээллийн давтамжийг бодитой тооцож төлөвлөх;

5. Хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн явцад урьдчилсан үнэлгээ хийж, хөгжлийн бодлого, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг өнөөгийн бодит нөхцөл байдалд тулгуурлан оновчтой төлөвлөж байгаа эсэх, дунд, богино хугацаанд улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд бодлогын төлөвлөлт харилцан уялдаатай байгаа эсэх, бодлогын хэрэгжилт, үр дүнг тодорхойлох шалгуур үзүүлэлт оновчтой эсэхийг тодорхойлж, төлөвлөлтийн алдаа гаргахгүй байхад анхаарч ажиллах;

6. Хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дагавар, үр нөлөөг үндэсний, салбарын, орон нутгийн түвшинд тодорхойлох үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн сан бий болгож, төлөвлөлт болон хяналт, шинжилгээ, үнэлгээнд ашиглах;

7. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд салбарын байгууллагын тооцоо, судалгаа, бодит нөхцөл байдалд үндэслэн гаргасан төслийн саналыг эцэслэн хэлэлцэж, УИХ-аар хэлэлцэх явцад өөрчлөлт оруулах тохиолдолд салбарын, мэргэжлийн байгууллагын оролцоог хангаж, шийдвэрлэж байхаар зохицуулалт хийх.

----oOo----

“МОНГОЛ УЛСЫН 2021-2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нэг.Зорилго

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээ болон техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, шийдвэр гаргах түвшинд мэдээллээр хангахад оршино.

Хоёр.Эрх зүйн үндэслэл, хамрах хүрээ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хугацаа дуусгавар болохоос дөрвөн сарын өмнө хэрэгжилтийн үнэлгээг Улсын Их Хуралд танилцуулна” гэж заасныг үндэслэж 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн схэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нийт 336 төсөл, арга хэмжээ батлагдсанаас санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн 150 төсөл, арга хэмжээ, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай 88 төсөл тус тус батлагдсан.

Гурав. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт

3.1.Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн 150 төсөл, арга хэмжээний хэрэгжилт

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн 150 төсөл, арга хэмжээ 9 бодлогын хүрээнд дараах байдалтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 1.Батлагдсан 150 төсөл, арга хэмжээний хэрэгжилт

д/д	Бодлогын хэрэгжилт	Хэрэгж-сэн	Хэрэгжиж байгаа	Хэрэгжээ-гүй	Нийт
1	Нэг.Үндэсний нэгдмэл үнэт зүйл	4	1	1	6
2	Хоёр.Хүний хөгжил	8	6	5	19
2.1	Биеийн тамир, спорт	-	-	3	3
2.2	Боловсрол	2	2	1	5
2.3	Шинжлэх ухаан, инновац	-	3	-	3
2.4	Эрүүл мэнд	6	1	1	8
3	Гурав.Амьдралын чанар ба дундаж давхарга	6	7	1	14
3.1	Зохистой хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнес	5	-	-	5

3.2	Нийгмийн хамгаалал	1	1	-	2
3.3	Орлогод нийцсэн орон байр	-	6	1	7
4	Дөрөв.Эдийн засаг	26	19	11	56
4.1	Аялал жуулчлал	1	2	-	3
4.2	Уул уурхай, хүнд үйлдвэр	3	5	2	10
4.3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр	5	1	6	12
4.4	Дэд бүтэц: барилга, хот байгуулалт	2	3	-	5
4.5	Дэд бүтэц: зам, тээвэр	9	4	1	14
4.6	Дэд бүтэц: эрчим хүч	6	4	2	12
5	Тав.Засаглал	8	1	-	9
6	Зургаа.Ногоон хөгжил	2	3	1	6
7	Долоо.Амар тайван, аюулгүй нийгэм	6	5	-	11
8	Найм.Бүс, орон нутгийн хөгжил	9	7	2	18
9	Ес.Улаанбаатар ба дагуул хот	3	7	1	11
	Нийт	72	56	22	150
	Эзлэх хувь	48%	37%	15%	100%


Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн нийт 150 төсөл, арга хэмжээнээс 72 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан, 56 төсөл хэрэгжиж байгаа, 22 төсөл хэрэгжиж эхлээгүй байна. Эдгээрийг төсөл, арга хэмжээ бүрээр хэрэгжсэн эсэхийг нэгдүгээр хавсралтад, бодлогын зорилго, зорилтоор тус бүрээр бүлэглэж хоёрдугаар хавсралтад дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 2.Батлагдсан 150 төсөл, арга хэмжээний хэрэгжилт

Бүрэн хэрэгжих хугацаа	2025 он	2026 он	2027 он	2028 он	2029 он	2030 он	Тодорхойгүй	Нийт
Хэрэгжиж байгаа	9	20	9	5	-	-	13	56
Хэрэгжээгүй	1	-	-	-	1	1	19	22
Нийт	10	20	9	5	1	1	32	78
Эзлэх хувь	13%	26%	12%	6%	1%	1%	41%	

Төсөл, арга хэмжээ хариуцагч байгууллага хэрэгжиж байгаа болон хэрэгжээгүй 78 төсөл, арга хэмжээг хэрэгжиж дуусах хугацааг төлөвлөж ирүүлснийг дээрх хүснэгтээр нэгтгэн харуулав.

График 1.Батлагдсан 150 төсөл, арга хэмжээний хэрэгжилт, бодлогын ангиллаар



Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээг бодлого тус бүрээр ангилж, дүгнэвэл үндэсний нэгдмэл үнэт зүйлийн хүрээнд хэрэгжүүлсэн 6 төсөл, арга хэмжээнээс 67 хувь, хүний хөгжлийн хүрээнд хэрэгжүүлсэн 19 төсөл, арга

хэмжээнээс 42 хувь, амьдралын чанар ба дундаж давхаргын хүрээнд хэрэгжүүлсэн 14 төсөл, арга хэмжээнээс 43 хувь, эдийн засгийн хүрээнд хэрэгжүүлсэн 56 төсөл, арга хэмжээнээс 46 хувь, засаглалын хүрээнд хэрэгжүүлсэн 9 төсөл, арга хэмжээнээс 89 хувь, ногоон хөгжлийн хүрээнд хэрэгжүүлсэн 6 төсөл, арга хэмжээнээс 33 хувь, амар тайван аюулгүй нийгмийн хүрээнд хэрэгжүүлсэн 11 төсөл, арга хэмжээнээс 55 хувь, бүс орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлсэн 18 төсөл, арга хэмжээнээс 50 хувь, Улаанбаатар ба дагуул хотын хүрээнд хэрэгжүүлсэн 11 төсөл, арга хэмжээнээс 27 хувь хэрэгжсэн байна.

Хүснэгт 3.Батлагдсан 150 төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хариуцагч байгууллагаар

д/д	Хариуцагч байгууллагын нэр	Хэрэгж-сэн	Хэрэгжиж байгаа	Хэрэгжээ-гүй	Нийт
1	Зам, тээврийн яам	14	5	1	20
2	Эрчим хүчний яам	7	7	4	18
3	Нийслэлийн ЗДТГ	5	7	3	15
4	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	5	8	-	13
5	Сангийн яам	8	5	-	13
6	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	6	1	6	13
7	Хууль зүй, дотоод хэргийн яам	8	3	-	11
8	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	3	5	2	10
9	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	4	4	1	9
10	Эрүүл мэндийн яам	6	1	1	8
11	Боловсролын яам	2	3	1	6
12	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	3	1	1	5
13	Шадар сайдын Ажлын алба	1	2	-	3
14	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	-	2	-	2
15	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	-	-	2	2
16	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	-	1	-	1
17	Эдийн засаг, хөгжлийн яам	-	1	-	1
Нийт		72	56	22	150

Хэрэгжиж байгаа 56 төсөл, арга хэмжээ төлөвлөгөөт хугацаанд дуусаагүй буюу хэрэгжилт удааширсан шалтгаан нь дэлхий даяар хөл хорио тогтоосонтой холбоотойгоор бараа материалын нийлүүлэлтийн саатал, цар тахлын дараах эдийн засгийн хүндрэл нөлөөлсөнтэй холбоотой гэж төсөл, арга хэмжээ хариуцагч байгууллагууд нь тайлагнасан байна.

Хэрэгжээгүй нийт 22 төсөл, арга хэмжээг шалтгаанаар нь ангилбал, санхүүжилтгүй буюу төсөв батлагдаагүйгээс 14 төсөл, арга хэмжээ, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулаагүйгээс 3 төсөл, арга хэмжээ, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс цуцлагдсан 1 төсөл, арга хэмжээ, холбогдох дээд шатны шийдвэрээр хэрэгжээгүй 1, худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон 2 төсөл, арга хэмжээ байна.

Зөвхөн санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн 150 төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг арга хэмжээний ажлын явцын хэрэгжилтийн хувиар он бүрээр баталсан ба шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтод хугацаандаа бүрэн хэрэгжсэн 21 төсөл, арга хэмжээ байна.

3.2.Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээний хэрэгжилт

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хариуцагч байгууллагаар харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 4.ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээ

Хариуцагч байгууллагын нэр	Хэрэгж-сэн	Хэрэгжиж байна	Хэрэгжээ-гүй	Нийт
1 Зам, тээврийн яам	17	-	13	30
2 Эрчим хүчний яам	23	-	-	23
3 Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	12	-	1	13
4 Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	3	-	6	9
5 Боловсролын яам	2	1	1	4
6 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	-	-	4	4
7 Эрүүл мэндийн яам	4	-	-	4
8 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	-	1	1	2
9 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2	-	-	2
10 Нийслэлийн ЗДТГ	-	-	4	4
11 Эдийн засаг, хөгжлийн яам	-	1	1	2
12 Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	-	-	1	1
Нийт	63	3	32	98
Эзлэх хувь	64%	3%	33%	

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр батлагдсанаас хойш 2025 оны эхний хагас жилд 63 төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулжээ. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажил нь эхэлсэн 3 төсөл, арга хэмжээ байгаа бол хэрэгжиж эхлээгүй 32 төсөл, арга хэмжээ байна.

Хэрэгжээгүй нийт 32 төсөл, арга хэмжээг шалтгаанаар нь ангилбал санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж чадаагүй 22 төсөл, арга хэмжээ, худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон 1 төсөл, арга хэмжээ, Концессын тухай хууль хүчингүй болсонтой холбоотой 1 төсөл, арга хэмжээ, газрын асуудал шийдэгдээгүй 2 төсөл, арга хэмжээ, холбогдох дээд шатны шийдвэрээр хэрэгжээгүй 3 төсөл, арга хэмжээ, хэрэгжээгүй шалтгааныг тайлагнаагүй 3 төсөл, арга хэмжээ тус тус байна.

3.3.Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай 88 төсөл, арга хэмжээний хэрэгжилт

Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтад нийт 88 төсөл, арга хэмжээ батлагдсан. Санхүүжилтийн эх үүсвэрийг 2021-2025 оны эхний хагас жилд 41 төсөл, арга хэмжээ бүтэн болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэгдсэн байна. Эдгээр 88 төсөл, арга хэмжээний санхүүжилт шийдвэрлэгдсэн байдлыг дөрөвдүгээр хавсралтад дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 4.УХОХ-т батлагдсан 88 төсөл, арга хэмжээний санхүүжилт шийдвэрлэгдсэн байдал

д/д	Хариуцагч байгууллагын нэр	Төсөл, арга хэмжээний тоо		
		Шийдвэрлэсэн	Шийдэгдээгүй	Нийт

1	Зам, тээврийн яам	15	16	31
2	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	5	6	11
3	Эрчим хүчний яам	4	5	9
4	Эрүүл мэндийн яам	4	1	5
5	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	4	1	5
6	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	3	1	4
7	Боловсролын яам	-	4	4
8	Эдийн засаг, хөгжлийн яам	-	3	3
9	Шатар сайд	-	3	3
10	Батлан хамгаалахын яам	1	2	3
11	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	1	1	2
12	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	2	-	2
13	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	-	2	2
14	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	1	-	1
15	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	1	-	1
16	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	-	1	1
17	Гадаад харилцааны яам	-	1	1
Нийт		41	47	88

Эх сурвалж: Хариуцагч байгууллага

Санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй 47 төсөл, арга хэмжээг хэрэгжээгүй шалтгаанаар ангилж үзвэл газрын өмчлөл, эзэмшил, ашиглалтын маргаантай холбоотойгоор 1 төсөл, арга хэмжээ, Концессын тухай хууль хүчингүй болсонтой уялдан 4 төсөл, арга хэмжээ, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулаагүйгээс шалтгаалан 21 төсөл, арга хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрлэж чадаагүй буюу удирдлага, зохион байгуулалтгүйгээс болж 21 төсөл, арга хэмжээ байна.

Дөрөв.Дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нийт 336 төсөл, арга хэмжээнээс 176 (52 хувь) нь хэрэгжсэн, 59 (18 хувь) нь хэрэгжиж байгаа, 101 (30 хувь) нь хэрэгжиж эхлээгүй байна.

Өөрөөр хэлбэл, **санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн 150 төсөл, арга хэмжээнээс 72 нь хэрэгжсэн, 56 хэрэгжиж байгаа, 22 нь хэрэгжиж эхлээгүй, санхүүжилтийн эх үүсвэр шаардалагатай 88 төсөл, арга хэмжээнээс 41 нь бүтэн болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн, 47 нь шийдвэрлэгдээгүй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах 98 төсөл, арга хэмжээнээс 63 нь хэрэгжсэн, 3 нь хэрэгжиж байгаа, 32 нь хэрэгжиж эхлээгүй байна.** Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт батлагдсан зарим төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй, хэрэгжилт удааширсан шалтгаан нь техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөлгүй арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн болох шийдвэрлэгдээгүй төсөл, арга хэмжээний жагсаалтад баталсан, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт батлагдаагүй, мөн 2020-2022 онд үргэлжилсэн цар тахлын нөлөөлөл болон түүнийг дагасан эдийн засгийн хүндрэл, бараа материалын ханган нийлүүлэлтийн доголдолтой холбоотой гэж дүгнэж байна.

Тав.Санал, зөвлөмж

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хийсэн хяналт-шинжилгээг үндэслэн дараах зөвлөмжийг дараагийн 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөж байна:

1. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөл, арга хэмжээ бүр нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн аль заалтыг хэрэгжүүлэхэд чиглэж байгааг тодорхой зааж тусгах;

2.Төсөл, арга хэмжээ бүрийн гарцын шалгуур үзүүлэлт, суурь түвшин болон зорилтот түвшинг тодорхой тусгаж, хэмжүүртэй болгох;

3. Хяналт-шинжилгээний шалгуур боловсруулахдаа Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн аль заалтын үр дүнгийн шалгуур үзүүлэлт болохыг хамтад нь тодорхой заах;

4.Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээ, болон техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээ бүрийн хариуцагч төсвийн ерөнхийлөн захирагчийг тодорхой заах;

5.Техник, эдийн засгийн үндэслэл болон зураг төсөл боловсруулсан төсөл, арга хэмжээг “санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-д нэмж тусгадаг байх зохицуулалтыг шийдвэрийн төсөлд тусгах;

6.Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтад санхүүжилт нь шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээг “санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-д нэмж тусгадаг байх зохицуулалтыг шийдвэрийн төсөлд тусгах;

7.Санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан болон техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний санхүүжилтийг эх үүсвэр тус бүрээр нарийвчлан;

8.Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтад “санхүүжилт шийдвэрлэгдээгүй” төсөл, арга хэмжээг тусгахгүй байх;

9.Төсөл, арга хэмжээг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн нэрээр бус, хэрэгжих бүтээн байгуулалтын арга хэмжээгээр нэрлэх;

10.Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөлгүй арга хэмжээг “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн болон шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээ”-нд тусгахгүй байх.

----oOo----

**Санхүүжилт шийдвэрлэгдсэн 150 төсөл, арга хэмжээнээс
2021-2025 оны эхний хагас жилд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний жагсаалт**

	Төсөл, арга хэмжээний нэр*	Байршил*	Санхүүжилтийн хугацаа* (оноор)	Төсөвт өртөг* (сая.төг)	Хэрэгжиж дууссан он	Хариуцагч
1	"Чингис хаан" хаад язгууртны музейн барилга	Улаанбаатар	2020-2021	53,066.50	2021	ССАЖЗЯ
2	Дуурь, бүжгийн эрдмийн театрын барилга	Улаанбаатар	2020-2022	54,607.50	2022	ССАЖЗЯ
3	Улсын драмын эрдмийн театрын барилга	Улаанбаатар	2020-2022	52,025.00	2024	ССАЖЗЯ
4	Төв номын сангийн барилга	Улаанбаатар	2020-2021	52,409.40	2024	ССАЖЗЯ
5	200 сургууль, 273 цэцэрлэг барих төсөл	Улсын хэмжээнд	2021-2024	996,800.0	2024	БоЯ
6	Боловсролын чанарын шинэчлэл төсөл	Улсын хэмжээнд	2015-2022	76,709.9	2023	БоЯ
7	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 нэмэлт санхүүжилт	Улсын хэмжээнд	2016-2021	73,769.20	2021	ЭМЯ
8	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 нэмэлт II төсөл	Улсын хэмжээнд	2020-2021	45,428.00	2021	ЭМЯ
9	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төсөл	Улсын хэмжээнд	2013-2021	92,326.90	2022	ЭМЯ
10	Цахим эрүүл мэнд төсөл (Дэлхийн банк)	Улсын хэмжээнд	2015-2021	49,959.70	2021	ЭМЯ
11	Цахим эрүүл мэнд төсөл (БНХАУ)	Улсын хэмжээнд	2015-2021	53,803.80	2021	ЭМЯ
12	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төсөл: Яаралтай үеийн тусламжийн нэмэлт санхүүжилт	Улсын хэмжээнд	2020-2021	85,177.50	2022	ЭМЯ
13	Тогтвортой амьжиргаа-3 төсөл нэмэлт санхүүжилт	Улсын хэмжээнд	2021-2022	34,071.00	2023	СаЯ
14	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг сайжруулах төсөл	Улсын хэмжээнд	2015-2022	66,737.60	2021	ГБХНХЯ
15	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	Улсын хэмжээнд	2017-2022	72,382.70	2022	ГБХНХЯ
16	Экспортын зээлийн шугам нээх төсөл	Улсын хэмжээнд	2013-2022	211,920.00	2021	СаЯ
17	Зээлийн батлан даалтын системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл	Улсын хэмжээнд	2016-2021	170,355.00	2025	ХХААХҮЯ
18	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх төсөл	Улсын хэмжээнд	2019-2023	70,981.30	2024	ГБХНХЯ

19	Эрдэнэтийн баяжуулах үйлдвэрт өргөтгөл, шинэчлэл, ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи, эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг байгуулах төсөл	Орхон	2020-2025	1,495,194.60	2024	АҮЭБЯ
20	Тавантолгойн нүүрсний бүлэг ордод технологийн шинэчлэл хийж, олборлолтыг төслийн хүчин чадалд хүргэх, нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах төсөл	Өмнөговь	2020-2024	2,983,717.20	2025	АҮЭБЯ
21	Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах төсөл	Дорноговь	2021	39,500.00	2022	АҮЭБЯ
22	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл	Улсын хэмжээнд	2016-2021	141,962.50	2022	ХХААХҮЯ
23	Биокомбинат үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл төсөл	Улаанбаатар	2020-2022	161,789.00	2024	ХХААХҮЯ
24	Мал аж ахуйн салбарын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	Улсын хэмжээнд	2020-2025	85,757.60	2025	ХХААХҮЯ
25	Экспортыг дэмжих төсөл	Улсын хэмжээнд	2016-2022	56,253.90	2023	ХХААХҮЯ
26	Газар тариалангийн техникийн шинэчлэл төсөл	Улсын хэмжээнд	2021-2023	34,104.00	2024	ХХААХҮЯ
27	Чингис хот-Дадал сум чиглэлийн хатуу хучилттай автозамын үргэлжлэл, 50 км	Хэнтий	2020-2022	45,000.00	2021	ЗТЯ
28	Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцын 1-4 турбогенераторын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчлэх	Улаанбаатар	2019-2022	246,450.00	2021	ЭХЯ
29	Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50 МВт-аар өргөтгөх	Дорнод	2020-2022	214,000.00	2024	ЭХЯ
30	Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл	Орхон	2018-2021	146,754.60	2021	ЭХЯ
31	Эрчим хүчний төсөл-2	Архангай, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Завхан, Нийслэл	2017-2022	155,975.50	2024	ЭХЯ
32	Эрчим хүчний сүлжээнд ашиглах том хэмжээний хуримтлуурын төсөл	Улаанбаатар	2021-2024	283,925.00	2024	ЭХЯ
33	Оюутолгой-Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Концессын эргэн төлөлт/	Өмнөговь, Дорноговь	2020-2022	91,423.90	2021	ЭХЯ
34	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын төсөл	Өмнөговь, Дорноговь	2019-2023	3,008,276.60	2023	ЗТЯ

35	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замын төсөл	Өмнөговь	2021-2022	950,688.30	2023	ЗТЯ
36	Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл /Азийн авто замын сүлжээний АН-3 - Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто замын шинэчлэл, Дархан-Алтанбулаг чиглэлийн авто замын засвар арчлалт, Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 58 км замын их засварын ажил/	Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Булган, Өвөрхангай	2019-2025	342,951.10	2023	ЗТЯ
37	Баруун бүсийн босоо тэнхлэгийн автозамыг хөгжүүлэх 2 дахь шатны төсөл /Азийн авто замын сүлжээний АН-4 - Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км автозам/	Ховд, Баян-Өлгий	2014-2023	401,366.20	2022	ЗТЯ
38	Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын “Шар тээг”-ийн уулзвараас Цогтэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төсөл /Концессын эргэн төлөлт/	Өмнөговь	2022-2023	101,992.40	2023	ЗТЯ
39	Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай автозам төсөл /Концессын эргэн төлөлт/	Увс	2020-2021	245,595.10	2024	ЗТЯ
40	Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай автозам төсөл /Концессын эргэн төлөлт/	Баянхонгор, Говь-Алтай	2021-2023	218,518.60	2020	ЗТЯ
41	Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай автозам төсөл /Концессын эргэн төлөлт/	Завхан	2020-2022	269,075.40	2021	ЗТЯ
42	Дархан-Алтанбулагийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай автозам төсөл /Концессын эргэн төлөлт/	Сэлэнгэ	2022-2025	241,701.80	2024	ЗТЯ
43	Дархан хотын бохир усны менежментийн төсөл	Дархан-Уул	2016-2021	51,059.40	2023	ХББОСЯ
44	Дэд бүтцийн хөгжил төсөл /Дархан-Уул, Сэлэнгэ, Сонгинохайрхан, Баянзүрх/	Дархан-Уул, Сэлэнгэ, Улаанбаатар	2021-2022	39,031.70	2022	ХББОСЯ
45	КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ, бэлэн байдлыг хангах төсөл	Улсын хэмжээнд	2020-2023	66,438.50	2025	СаЯ
46	Төлбөрийн системийн шинэчлэл төсөл	Улсын хэмжээнд	2015-2022	56,785.00	2022	СаЯ

47	Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих төсөл-2	Улсын хэмжээнд	2017-2022	32,257.50	2023	СаЯ
48	Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт, шалгалтын тоног төхөөрөмж	Улсын хэмжээнд	2019-2021	114,143.90	2024	СаЯ
49	Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын лабораторийн тоног төхөөрөмж	Улсын хэмжээнд	2019-2021	38,310.00	2023	СаЯ
50	Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл	Улаанбаатар	2020-2022	53,945.80	2024	ХЗДХЯ
51	Нэг иргэн-Нэг бүртгэл хөтөлбөр	Улсын хэмжээнд	2020-2025	42,563.00	2025	ХЗДХЯ
52	Улсын бүртгэлийн ерөнхий газар, орон нутаг дахь улсын бүртгэлийн газар, хэлтсийн архив, үйлчилгээний байр, тохижилт, техник хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, хадгалалт хамгаалалт	Улсын хэмжээнд	2019-2025	77,984.50	2025	ХЗДХЯ
53	Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжийг шинэчлэх төсөл	Улаанбаатар	2020-2021	41,737.00	2025	НЗДТГ
54	Байгаль орчинд ээлтэй, цахилгаан болон хийн хөдөлгүүр хосолсон нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл	Улаанбаатар	2021-2030	638,759.10	2025	НЗДТГ
55	Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл	Улсын хэмжээнд	2019-2021	49,853.70	2022	ШС
56	Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах төсөл	Улаанбаатар	2021-2024	86,856.00	2025	ХЗДХЯ
57	Цагдаагийн байгууллагын авто парк шинэчлэл	Улсын хэмжээнд	2021-2024	39,795.80	2025	ХЗДХЯ
58	Хил хамгаалах байгууллагын авто парк шинэчлэл	Улсын хэмжээнд	2020-2025	42,110.00	2025	ХЗДХЯ
59	Хилийн боомтуудыг “Дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем”-ээр төхөөрөмжилж, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд "Ухаалаг цахим" технологийг нэвтрүүлж, шалгалтын техник, хэрэгслээр хангах, цэргийн холбооны техник хэрэгсэл, хүн нэг бүрийн тусгай хэрэгслийг шинэчлэх	Улсын хэмжээнд	2020-2025	40,800.00	2025	ХЗДХЯ
60	Ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, хорихоос бусад төрлийн ял эдлүүлэх бодлогын хэрэгжилтийг хангуулах	Улсын хэмжээнд	2020-2025	32,800.00	2025	ХЗДХЯ

